



МОНГОЛЫН СУРГУУЛЬД ТРАНС СУРАГЧ БАЙХ НЬ

Кэйс цуглуулгын аргаар хийсэн чанарын судалгаа

МОНГОЛЫН СУРГУУЛЬД ТРАНС* СУРАГЧ БАЙХ НЬ

Кэйс цуглуулгын аргаар хийсэн чанарын судалгаа

Судлаач: Ганбаатарын Доржжанцан

Редактор: Энхболдын Энхмаа

Судалгаанд хувь нэмэр оруулсан: Мөнхбатын Өүлэн

Англиас монгол хэл рүү орчуулсан: Төвсанаагийн Бэхцэцэг

Фото зураг ЛГБТ төв

Транс* - Энэхүү судалгааны бүтээлд бид транс болон трансжендер хэмээх нэр томъёог өөрийн хүйсийг төрөх үед нь тэмдэглэгдсэн хүйсээс өөрөөр баримжаалан илэрхийлдэг хүйсийн төрөл бүрийн баримжаа илэрхийллүүдийн нэршилд толгой нэр томъёо болгон эн тэнцүү сэлгэн хэрэглэсэн болно.

Эшлэл авах: Ganbaatar, D., Enkhbold, E., & Munkhbat, O. (2023). *Being trans* students at school in Mongolia: Collective case studies*. Ulaanbaatar.



EDUCATION OUTLOUD
advocacy & social accountability

GPE
Transforming
Education




Бидний юу хэлэхийг сонсож, хэлэх үгэнд минь итгээч. Бид хүртээмжгүй нийгэмд, ялгаварлан гадуурхалт дунд амьдарч байна. Дуу хоолойг минь хүмүүс зүрх сэтгэлээрээ сонсож, өөрчлөлтийг авч ирэхэд бидэнтэй нэгдээсэй гэж хүснэ. Ингэх нь туйлын хялбар, бас туйлын чухал юм шүү. Бид өөрөөрөө байж чадвал уйтгар гуниг, айдас түгшүүрээс ангид зүйл мэдэрч чадна гэж бодно. Тийм ч учраас боловсрол энд онцгой үүрэгтэй. Ирээдүйд бүхий л бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаа илэрхийллийг хүлээн зөвшөөрдөг хүртээмжтэй боловсролын тогтолцоотой болж, хүн бүр өөрийн хүсэл мөрөөдлөөр амьдраасай хэмээн би хүснэ. Боловсролын тогтолцоогоор дамжуулан сурагчдын дунд төдийгүй багш нарын мэдлэг, мэдээллийг сайжруулахыг зоривол сайн сан. Хэрэв бид хүмүүсийг зөв мэдээллээр хангаж чадвал нийгэмд тэд бие биедээ илүү сайнаар хандах болно гэж би итгэдэг.



**Ганзоригийн ЭНХЖИН, эрэгтэй
Транс суралцагч, транс эрхийн активист**

(Энхжин бол Ази, Номхон далайн бүсийн Суурь болон Насанд хүрэгчдийн Боловсролын Нийгэмлэгийн залуусын төлөөлөл юм. Бангкок дахь НҮБ-ын Боловсрол, Шинжлэх Ухаан, Соёлын Байгууллагаас түүнийг 2022 оны аравдугаар сард Тэгш Боловсрол: Тэгш байдлын Төлөө Хамтдаа хэмээх Олон Улсын Хоёрдугаар Конференцид нэр дэвшүүлэн оролцуулсан бөгөөд тус хурлын үеэр дэлхийн өнцөг булан бүрээс ирсэн 4,000 орчим төлөөлөгчдөд суралцагч бүрд ээлтэй, илүү хүртээмжтэй, тэгш боловсролын тогтолцоог бий болгох тухай өөрийн мөрөөдлийг хуваалцан урам зориг өгсөн билээ.)

Агуулга

Талархал	6	Дөрөвдүгээр бүлэг: Сургууль	
Нэр томъёоны тайлбар	7	Хүйсээр ангилан хуваах соёл	23
		Технологи, биеийн тамирын хичээл	24
		Дүрэмт хувцасны журам	26
		Ариун цэврийн өрөө	29
		Сургалтын хөтөлбөр	31
		Багш нарын сөрөг хандлага	36
Нэгдүгээр бүлэг: Танилцуулга			
Соёл, хэвлэл мэдээлэл	10		
Монголын транс өсвөр, залуу үе	11		
Сургуулийн сургалтын хөтөлбөр	12		
Хууль эрхзүй, бодлого	13		
			
Хоёрдугаар бүлэг: Судалгааны дизайн		Тавдугаар бүлэг: Хүчирхийлэл, дарамт	
Транс Зөвлөлдөх Бүлэг	16	Үг хэлээр хүчирхийлэх	42
Судалгааны аргазүй	16	Би махбодын хүчирхийлэл	43
Дата анализ	18	Бэлгийн дарамт	45
Ёс зүйн асуудал	18		
Судалгааны хязгаарлагдмал байдал	19	Зургаадугаар бүлэг: Сэтгэцийн эрүүл мэнд	
		Хүчирхийлэл, ялгаварлан гадуурхалтын нөлөө	48
		Сэтгэцийн эрүүл мэндийн үр дагавар	49
		Өөрийгөө тусгаарлах	49
		Муу зуршил, өөрийгөө гэмтээх	50
		Амиа егүүтгэх сэдэл, оролдлого	51
Гуравдугаар бүлэг: Оролцогчид			
Оролцогчдын демографик	21		

Долоодугаар бүлэг: Сургуулиас гадуурх амьдрал

Гэр бүл	54
Активизм	57
Мэдээлэл олж авах	58

Наймдугаар бүлэг: Дүгнэлт, зөвлөмж

Дүгнэлт	61
Зөвлөмж	62

Төрийн байгууллага, Засгийн Газрын агентлагуудад	62
--------------------------------------------------	----

Сургууль, боловсролын байгууллагын мэргэжлийн ажилтнуудад	62
-----------------------------------------------------------	----

Сэтгэцийн эрүүл мэндийн салбарын мэргэжилтнүүдэд	63
--------------------------------------------------	----

Цааш судлах нь	63
----------------	----



Талархал

Энэхүү судалгааг хийж үр дүнг нь гаргахад маш олон хувь хүн, албан байгууллага хувь нэмрээ оруулан оролцсон билээ. Юуны түрүүнд дурдахад транс болон хүйсийн хэвшмэл байдалд үл нийцэх сурагчдын нөхцөл байдлын талаарх судалгааны хэрэгцээ буйг олж харж, шаардлагатай санхүүжилтээр хангасан “Бүх нийт боловсролын төлөө!” Иргэний нийгмийн үндэсний эвслийн дэмжлэг байгаагүй сэн бол энэхүү судалгаа хийгдэхгүй байх байлаа. Судалгааны ажилтай холбоотой зохион байгуулалтын ажлуудад үнэт цагаа зориулж мөн судалгааны туршид бүтээлч санал шүүмжээ өгч байсан Дондогдуламын Тунгалаг, Ядамсүрэнгийн Мөнхчимэг нарт тусгайлан талархал илэрхийлмээр байна. Мөн ЛГБТ Төвийн хамтран зүтгэгч, анд нөхөд болох Энхболдын Энхмаа, Мөнхбатын Өүлэн нарт энэхүү судалгааны ажилд тус тусын хувь нэмрийг оруулан хичээнгүйлэн ажилласанд талархъя.

Энэхүү судалгааны тайланг хянан засварласан Ник Смалдонд тусгайлан гүнээ талархъя.

Эцэст нь, судалгаанд оролцсон бүх транс сурагчдадаа чин сэтгэлийн халуун талархал илэрхийлж байна. Амсаж туулж буй амьдралын туршлагынхаа талаар бид бүхэнтэй хуваалцсан хүүхэд нэг бүрд маш их баярлалаа. Бидний асуусан олон асуулт та нарын хөндүүр сэтгэлийг өвтгөж, заримынх нь хувьд сэтгэлзүйг чинь гэмтээсэн үйл явдлуудыг эргэн дурсахад хүргэсэн гэдгийг бид мэднэ. Өдөр тутмын амьдралаараа харуулж буй зориг тэвчээр, даван туулах эрмэлзэл чинь бид бүхнийг зоригжуулж, та нарын минь энэхүү оролцоо ил гаргаж, өөрчлөлт хийх шаардлагатай байгаа тэрхүү ялгаварлан гадуурхах тогтолцоо, нийгэм дэх сорилт бэрхшээлийн талаар үнэн бодит түүхийг өгүүлэхэд бидэнд тусалсан билээ.

Нэр томъёоны тайлбар

ЛГБТИК+

Лесбиян, гей, бисексуал, трансжендер, күйр, интерсекс болон “+” тэмдгээр бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаа илэрхийллийн хязгааргүй олон янз байдлыг илэрхийлэн нэрлэдэг товчилсон үг юм.

Лесбиян

Сэтгэл хөдлөл, хайр дурлал, бэлгийн дур хүслийн хувьд өөр бусад эмэгтэйд татагддаг эмэгтэй хүн.

Гей

Сэтгэл хөдлөл, хайр дурлал, бэлгийн дур хүслийн хувьд өөр бусад эрэгтэйд татагддаг эрэгтэй хүн.

Бисексуал

Сэтгэл хөдлөл, хайр дурлал, бэлгийн дур хүслийн хувьд нэгээс илүү хүйс, жендер, хүйсийн баримжаа бүхий хүмүүст татагддаг хүн. Гэхдээ тэдэнд нэгэн зэрэг, ижил хэв маяг, эрчмээр татагддаг байх албагүй.

Трансжендер

Төрөх үед тэмдэглэгдсэн хүйстэй холбоотой давамгайлагч соёл, нийгмийн хүлээлтээс өөр хүйсийн баримжаа, илэрхийлэлтэй хүмүүсийг нэрлэдэг толгой нэр томъёо.

Күйр

Хүйсийн баримжаа, илэрхийлэл болон, аль эсвэл бэлгийн чиг баримжааны хувьд давамгайлагч соёл, нийгмийн хэм хэмжээнд багтдаггүй хүмүүсийг нэрлэдэг толгой нэр томъёо.

Интерсекс

хүйсийн онцлог шинж, нөхөн үржихүйн анатомийн хувьд олон янзын ялгаатай төрсөн хүмүүсийг нэрлэдэг нэр томъёо. Интерсекс гэдэгт олон төрлийн ялгаатай байдал багтдаг бөгөөд үүнээс дурдвал бэлэг эрхтэн, хромосом, бэлгийн булчирхай, дотоод бэлэг эрхтнүүд, гормон ялгаруулалт, гормон зохицуулалт болон хоёрдогч хүйсийн онцлог шинжийн ялгаатай байдал зэрэг болно.

Хүйс

Эрэгтэй, эмэгтэй, интерсекс хүмүүсийг хооронд нь ялгах нөхөн үржихүйн анатоми, онцлог шинж.

Төрөхөд тэмдэглэгдсэн хүйс

эрэгтэй, эмэгтэй, интерсекс хэмээн хүүхдийг төрөх үед нөхөн үржихүйн гадна анатомид тулгуурлан эмч эсвэл эх баригчийн тодорхойлсон хүйс.

Бэлгийн чиг баримжаа

Сэтгэл хөдлөл, хайр дурлал, бэлгийн дур хүслийн хувьд бусад хүмүүст татагдах төрөлхийн, тэвчиж үл болох байдал. Жич: Хүний бэлгийн чиг баримжаа нь түүний хүйсийн баримжаа, илэрхийллээс ангид бие даасан зүйл юм.

Жендер

Эрэгтэй, эмэгтэй хүн, хүү, охины тодорхойлолтын талаар соёл, нийгмийн бүтээсэн ойлголт, үзэл, хандлага. Үүнд хэм хэмжээ, зан үйл, эмэгтэй, эрэгтэй хүн, хүү, охины үүрэг, тэдний хоорондын харилцаа холбоо зэрэг багтана.

Хүйсийн баримжаа

Хүн өөрийгөө эрэгтэй, эмэгтэй, аль алиных нь холимог эсвэл аль нь ч биш хэмээн сэтгэлийн гүнд мэдрэн ойлгох байдал. Хүн өөрийгөө хэн гэж ухамсарлан мэдэрч байгааг, өөрийг нь юу гэж дуудаж болохыг хэлнэ. Хүний хүйсийн баримжаа нь төрөх үед тэмдэглэгдсэн хүйстэй адил эсвэл өөр байж болно.

Жендер байнари

Хүйсийг эрэгтэй, эмэгтэй хэмээх хоёр ангилалд хатуу зааглан тодорхойлсон тогтолцоо. Хүмүүсийн хүйсийн баримжаа нь төрөх үед тэмдэглэгдсэн хүйстэй, мөн хүйсийн илэрхийлэл, жендерийн үүрэг нь соёл, нийгмийн хүлээлттэй нийцэж байх ёстой мэт үздэг үзэл.

Хүйсийн нийцэмжгүй байдал

хүн төрөхөд тэмдэглэгдсэн хүйсээсээ өөр хүйсийн баримжаа илэрхийлэлтэй байхыг хэлэх бөгөөд энэхүү үл нийцэл нь сэтгэц, сэтгэлзүйн онцгой дарамт учруулдаг төлөв байдал.

Хүйсийн шилжилттэй холбоотой эрүүл мэндийн хамгаалал

Трансжендер хүмүүст зориулсан тэдний мэдэрч буй хүйсийн нийцэмжгүй байдлыг багасгах, сэтгэцийн эрүүл мэндийг дэмжих, амьдралын чанарыг сайжруулах эмнэлзүй, нийгэм, сэтгэцийн шаардлагатай эрүүл мэндийн үйлчилгээ.

Нонбайнари

Өөрийгөө гагцхүү эрэгтэй, эсвэл эмэгтэй хэмээн илэрхийлдэггүй хүнийг нэрлэдэг тэмдэг нэр. Нонбайнари хүмүүс өөрийгөө эрэгтэй, эмэгтэй аль алинаар нь, аль эсвэл хоёр хүйсийн дунд хаа нэгтээ нь, эсвэл аль алинаар нь ч илэрхийлэхгүй байж болно. Түүнчлэн нонбайнари нь ажендер, бижендер, жендергүйр, жендерийн хувьд хувьсамхай гэх зэрэг илэрхийллүүдийг багтаасан толгой нэр томьёо.

Сизжендер

Хүйсийн баримжаа илэрхийлэл нь төрөхөд тэмдэглэгдсэн хүйстэй нь нийцэмжтэй байдаг хүмүүс.

Нээлттэй илэрхийлэх/ Ил гарах

Хүн өөрийн бэлгийн чиг баримжаа болон/аль эсвэл хүйсийн баримжаа илэрхийллийн тухай таньж мэдэх, хүлээн зөвшөөрөх, талархах, түүнчлэн үүнийгээ бусдад илээр илэрхийлж эхлэх үйл явц

БЧБХБ

Бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаа



Нямдоржийн Анараа маань Боловсрол эвслийг үүсгэн байгуулагчдын нэг болох ЛГБТ төвийг удирдаж байсан юм. Монголын нийгэмд хамгийн их ялгаварлан гадуурхагддаг бүлгийн эрхийн төлөөх тэмцлийг удирдана гэдэг хэн хүний чадах ажил биш. Хүний эрхийн төлөө тэмцэгчдийн дунд мэдлэг, ур чадвар, авьяас билиг, шүлүүн чигч байдлаараа ялгарч үлгэрлэдэг нэгэн байлаа. Түүний эхлүүлсэн санаачлага үйл хэрэг нь үргэлжид шинэ өнгө, дуу хоолой байсныг үүрд санан дурсах болно. Боловсрол эвслийн хамт олон бэлгийн цөөнх хүүхэд, залуусын эрх тэгш сурч боловсрох эрхийн төлөө хийсэн бүхнийг үнэлэн дурсахын зэрэгцээ залгамжлан үргэлжүүлэх болно.

“Бүх нийт боловсролын төлөө!” Иргэний нийгмийн үндэсний эвсэл



НЭГДҮГЭЭР БҮЛЭГ:

Танилцуулга

СОЁЛ, ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЭЛ

Далан жилийн түүхтэй социалист дэглэмээс өмнө 17 дугаар зууны эцэс хүртэл бөө мөргөл нь Монголчуудын соёл, уламжлалд давамгайлах байр суурь эзэлж байв (Nyamdorj, 2006). Бөө мөргөл бүхий нийгэмд иргэд трансжендер болон жендерийн олон янз байдлыг нийтээр ойлгож хүлээн зөвшөөрдөг байсан бөгөөд зарим бөө урвуу жендерийн үүрэгтэй байсан нь уугуул америкчуудын бөөгийн уламжлалтай төстэй байв (Devereux, 1937). 17 дугаар зууны сүүл үеэс эхлэн улс төрийн зорилготойгоор Монгол оронд Бурханы шашин түгэн дэлгэрснээр жендерийн олон янз байдлыг хүлээн зөвшөөрөх уламжлалт хандлага Бурханы шашны үйлийн үр (карма)-ийн номлолоор тайлбарлагдах болсон юм. (Нямдорж, 2006). Харамсалтай нь 1921-1990 оны хооронд социалист дэглэм тогтсоноор трансжендер болон жендерийн олон янз байдлын талаарх өмнөх ойлголт замхарч, ижил хүйсийн бэлгийн харилцааг социалист Монгол улс яллан шийтгэж байсан (Тэрбиш, 2013) тул ЛГБТИК+ иргэдийн дунд айдас түгшүүр ноёлж, тэдэнд тулгамддаг асуудлууд нам гүм болсноор энэ нь 1990 оны эхэнд ардчилалд шилжих үе хүртэл үргэлжилжээ (Нямдорж, 2006). Ийнхүү орчин цагийн түүхэн дэх ЛГБТИК+ иргэдийн эрхийн хөдөлгөөний үнэмлэхүй ололт дэвшлээс ангид хоцорсон Монгол оронд өнөөг хүртэл транс болон жендерийн олон янз байдлыг олон нийт буруу ойлгож, сөрөг хандлагаар хүлээн авсаар ирэв (Ганбаатар ба бусад, 2021).

Транс болон хүйсийн хэвшмэл байдалд үл багтах хүмүүс Монголын соёл, хэвлэл мэдээллийн талбарт үзэгдэж байгаагүй бөгөөд 17 дугаар зууны сүүл үе хүртэл бөөгийн уламжлалаас улбаатай хүлээн зөвшөөрөх хандлага нийгэмд оршиж байсан. Гэвч жендерийн олон янз байдалтай холбоотой бичгээр үлдээсэн түүх туйлын ховрын дээр өнөөг хүртэл транс болон жендерийн олон янз байдал бүхий хүмүүсийг нэрлэх тогтсон үг ч байсангүй. Ардчилалд шилжсэнээс хойш нийтийг хамарсан мэдээллийн хэрэгслүүдийн хэвлэн нийтлэх, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө баталгаажсанаар Ган-Од¹, Нараа² зэрэг тухайн үедээ гей залуус гэгдэж байсан хүмүүстэй хийсэн ярилцлага, сурвалжилгуудаар дамжуулан Монгол дахь ЛГБТИК+ хүмүүсийн тухай олон нийт олж мэдэх болжээ.

Гэсэн хэдий ч нийтийг хамарсан хэвлэл мэдээллийн хэрэгслүүд энэ асуудалд

- 1 Ганбүүш хэмээх нэрээр мөн танигдсан, анхны нээлттэй трансжендер эмэгтэйчүүдийн нэг. Тайланд улсад хүйс шилжүүлэх мэс засалд орсны дараа хэвлэл мэдээллийн өмнө ил гарсан анхны эмэгтэй юм. Сүүлд өөрийгөө интерсекс хэмээн олон нийтэд мэдэгдсэн.
- 2 Ардчилсан нийгмийн шилжилтийн үед гей эрчүүдийг хэвлэл мэдээллийн хэрэгслүүд дуулиан шуугиантайгаар мэдээллэж байснаас үүдэн олны танил болж гей гэдгээ мэдэгдсэн анхны эрчүүдийн нэг.

хэт хайхрамжгүй хандаж олон нийтийн харалган тоомжиргүй байдлын тусгал болсноор трансжендер илэрхийллийг Монгол бус хэмээн дуулиан шуугиан болгож, ёс зүйгүй сурвалжилгуудаараа тэд социализмын үеийн ёсон бус хэмээх номлолыг олон нийтийн дунд улам бататгаж өгсөн юм (Нямдорж, 2006). Өнөөдөр цөөнгүй трансжендер эмэгтэй олонд ил болсон төдийгүй нийгмийн сүлжээнд ихээхэн алдартай (харин трансжендер эрчүүд төдийлөн ил бус) байдаг бол транс болон хүйсийн хэвшмэл байдалд үл багтах хүмүүсийг ихэвчлэн буруугаар ойлгож, нийгэм дэх хэвшмэл хандлагыг улам өөгшүүлэхүйц байдлаар шог наргиа болгон дүрсэлсээр байна. Монгол дахь жендерийн тэгш байдлын төлөөх, феминист хөдөлгөөнүүдийн хувьд транс иргэдийн эрхийг багтаадаггүй хэмээн дүгнэж болох бөгөөд олны үзэл бодолд нөлөө бүхий улс төрч, уран бүтээлч, инфлүэнсэрүүд, түүнчлэн хүний эрхийн хуульчид хэмээн өөрийгөө тодорхойлсон хүмүүс “трансжендер” гэх ойлголтыг хэт туйлширсан өнцгөөс тогтмол буруушаасаар байдаг билээ.

МОНГОЛЫН ТРАНС ӨСВӨР ЗАЛУУ ҮЕ

Монголын хүн амын залуу үе харьцангуй бага судлагдсан (Даваасамбуу ба бусад, 2019) бөгөөд транс болон жендерийн хэвшмэл байдалд үл багтах өсвөр залуу үе урьд өмнө ямар нэг судалгаанд багтаж байгаагүй юм. Тиймдээ ч нийгмийн бодлогоос гадна үлдэж, тэдний талаар мэдээлэл хязгаарлагдмал байдаг (НҮБ, 2014). Эрэгтэй, эмэгтэй гэсэн жендерийн ангиллаас давж судалсан судалгааны мэдээ, тоо баримт хязгаарлагдмал хэдий ч үндэсний хэмжээний тоо баримтаас харахад өсвөр залуу үеийн дунд ганцаардал, сэтгэл зовних асуудлаас үүдсэн амиа егүүтгэх сэдэл, оролдлого өндөр хувьтай байдаг. Түүнчлэн согтууруулах ундаа хэрэглэх, тамхи татах зэрэг хорт зуршилтайн дээр сургууль дээрээ зөрчил тэмцэлтэй байдаг аж (Даваасамбуу ба бусад, 2017)

Цаашилбал, хүйсийн баримжаан дээр үндэслэсэн ялгаварлан гадуурхалт, гутаан доромжлох хандлага нь өсвөр залуу үеийн дунд үеийнхнээ дээрэлхэх, нийгмийн харилцаанд ганцаардуулах, түлхэх зэрэг илүү ноцтой асуудлуудын үндэс болдог. НҮБ-ын мэдээлснээр гэр бүлдээ үл хүлээн зөвшөөрөгдөх, мэргэжлийн хүмүүс болон ойр хүрээллээсээ дэмжлэг авч чадахгүй байх, нийгмээс сөрөг хандлага хүлээн авах зэрэг шалтгаанаас үүдэн дийлэнх залуустай харьцуулахад гей, лесбиян залуусын дунд амиа егүүтгэх магадлал 4 дахин их, транс болон хүйсийн хэвшмэл байдалд үл багтах хүүхэд залуусын хувьд энэ нь 10 дахин их байдаг гэжээ (НҮБ, 2015).

Монголын боловсролын байгууллагын орчин дахь транс болон хүйсийн хэвшмэл байдалд үл багтах хүүхэд залуусын амсаж туулж буй амьдралын туршлагын талаар мэдээ, баримт хомс ч гэлээ олон улсын хэмжээнд энэхүү нийгмийн бүлэг нь үе тэнгийн дээрэлхэлт, мөн тэгш хамруулсан боловсролын бодлого дутмаг, багш нар, сургуулийн удирдлагын зүгээс дэмжлэг үзүүлдэггүй зэрэг шалтгаанаас үүдэн сэтгэлзүйн ихээхэн дарамттай явдаг хэмээн тодорхойлсон нь бий (Grossman & D’augelli, 2006). Түүнчлэн, транс хүүхэд залуусын гуравны хоёр нь сургууль дээрээ үе тэнгийн дээрэлхэлтэд өртөж, энэ нь тэдний гуравны нэгийг хичээл таслах, сургуулиас завсардахад хүргэдэг аж (НҮБ, 2015). ЛГБТ Төв (2016)-ийн тоо баримтаар бол Монгол дахь ЛГБТИК+ хүүхэд залуусын 79 хувь нь ямар нэг төрлийн дээрэлхэлт,

ганцаардуулалт, ялгаварлан гадуурхалтыг амсаж туулж байсан бол 9.4 хувь нь онц хүнд бие махбодын хүчирхийлэлд өртөж байжээ. “Бүх нийт боловсролын төлөө!” Иргэний нийгмийн үндэсний эвслээс ЛГБТИК+ сурагчдын дунд удирдан явуулсан чанарын судалгаагаар ЛГБТИК+ сурагчдад чиглэсэн багш нарын хандлага нь ялгаварлан гадуурхсан, тодорхой хэмжээнд хүчирхийлэх төлөвтэй байгаа үр дүнг харуулж байна (Отгонбаатар, 2011).

Цаашлаад, 2015, 2016 онд үндэсний хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй сэтгэцийн эрүүл мэндийн төвүүд, шашны байгууллагууд, ялангуяа христийн сүмийн дэргэдэх нийгмийн ажил, сэтгэцийн эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлдэг төвүүдээр дамжуулан сэтгэцэд суурилсан эрүүл мэндийн үйлчилгээ авсан транс хөвгүүдэд тэдний энэхүү трансжендер мэдрэмж түр зуурынх бөгөөд удахгүй арилж, эмчлэгдэнэ хэмээн хэлдэг ажээ (ЛГБТ Төв, 2016). Өөр нэгэн судалгаанд (Ганбаатар ба бусад, 2021) ЛГБТИК+ хүүхэд залуус ахлах сургуульд байсан жилүүдээ хамгийн хүнд хэцүү, дарамттай, үе тэнгийн дээрэлхэлтээс үүдэлтэй байнгын бие махбодын хүчирхийлэл, сэтгэлзүйн айдас түгшүүртэй амьдарч байсан үе хэмээн тодорхойлсон байна. Ахлах сургуулийн багш нарын ЛГБТИК+ сурагчдад чиглэсэн хандлагыг ялгаварлан гадуурхсан гэж дүгнэж болох бөгөөд энэ нь сурагчдыг ойр хүрээлэл, нийгмээс тусламж авах аргагүй болгохоос гадна үе тэнгийн дээрэлхэлтээс сэргийлэн хамгаалах бус харин ч улам гаарах нөхцөлийг бүрдүүлж байна. Монголын хувьд сургуулийн орчинд үг хэлээр доромжлох бие махбодод хүч хэрэглэх зэрэг үе тэнгийн дээрэлхэлт нийтлэг тохиолддог бөгөөд транс сурагчид хүйсийн эмэгтэйлэг, эсвэл эрэгтэйлэг баримжаа илэрхийллээсээ болж энэ мэт ноцтой хүчирхийллийн бай болсоор байна (Ганбаатар ба бусад, 2021).

БАГА, ДУНД БОЛОВСРОЛЫН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР

Монгол Улсын Эрүүл Мэндийн Яам, Гэгээрлийн Яам (одоогийн Боловсрол, Шинжлэх Ухааны Яам)-наас 1997 онд НҮБ-ын Хүн амын сангийн дэмжлэгтэйгээр бэлгийн боловсролын сургалтын хөтөлбөрийн шинэчлэлийг бага болон дунд боловсролын түвшинд хийж эхэлсэн билээ (Өнөрзүл, 2020). Ийнхүү Монгол Улсын Засгийн газар Дэлхийн эрүүл мэндийн байгууллагатай хамтран эрүүл мэндийн боловсролын арван үндсэн сэдвийг тодорхойлжээ. Есдүгээр ангийн эрүүл мэндийн боловсролын сургалтын хөтөлбөрт аюулгүй бэлгийн харилцаа, бэлгэвч хэрэглэх, бэлгийн харилцаанаас татгалзах, бэлгийн чиг баримжаа, бэлгийн харилцаа, бэлгийн зан үйл, аюулгүй бэлгийн харилцаа болон согтууруулах ундааны хэрэглээ зэрэг олон чухал сэдвийг оруулж өгсөн байдаг. 1998 оны Эрүүл мэндийн боловсролын сургалтын хөтөлбөрт бэлгийн чиг баримжааны тухай оруулж өгсөн нь сурагчдыг бэлгийн олон янз байдлын талаар таньж мэдэхэд онцгой хувь нэмэр оруулсан гэж үздэг. (Barcelona et al, 2002). Тус сургалтын хөтөлбөрт бэлгийн чиг баримжаа (гэвч хүйсийн баримжаа илэрхийлэл үүнд багтаагүй) хэмээх сэдвийг оруулж чадсан ч багш нар үг сэдвийг тэр бүр заадаггүй, заасан ч чанартай заадаг эсэх нь эргэлзээтэй бөгөөд ЛГБТИК+ сурагчдын мэдэгдсэнээр зарим багш нар сөрөг, гомофоби хандлагатай байдаг хэмээн ЛГБТ Төвийн судалгаанд дурджээ (Нямдорж & ХЭҮК, 2013). Монгол Улсын Засгийн Газраас 2014 онд бага, дунд боловсролын байгууллагын бүх түвшинд хэрэгжих Суурь боловсролын хөтөлбөрөөс бүхэлд нь хасах хүртэл энэхүү эрүүл

мэндийн боловсролын хөтөлбөр хэрэгжиж байв. Засгийн Газрын албаны хүмүүс тус эрүүл мэндийн боловсролын сургалтын хөтөлбөрийн агуулга нь Нийгмийн ухаан, Биологи ба Биеийн тамир зэрэг хичээлийн агуулгад багтан орсон хэмээн тайлбарлаж байсан аж (Үлэмж, 2018).

Хожим 2018 онд Монгол Улсын Засгийн газар НҮБ-ын Хүн амын сан болон НҮБ-ын Хүүхдийн сантай хамтран Эрүүл мэндийн боловсролыг сургалтын хөтөлбөрт дахин нэвтрүүлсэн нь Монголын боловсролын салбарт нэн шаардлагатай байсан дэвшил болж чадсан юм. Шинэчилсэн сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхийн тулд Монгол дахь НҮБ-ын Хүн амын сангаас хүний нөөцийг чадавхжуулах хөтөлбөр боловсруулж, үндэсний хэмжээний 19 үндэсний сургагч багш, орон нутагт 90 сургагч багшийг бэлтгэжээ. Сургагч багш нар улсын хэмжээнд эрүүл мэндийн боловсрол олгох багш нарын чадавхыг сайжруулах үүрэг авсан бөгөөд ийнхүү 2018 оноос эхлэн Эрүүл мэндийн боловсрол нь дунд сургуулийн бие даасан хичээл болж чадсан юм (НҮБ-ын Хүүхдийн сан, 2019). Шинээр нэвтрүүлсэн Эрүүл мэндийн боловсролын хөтөлбөрийн 9 дүгээр ангийн хичээлд бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаа илэрхийлэл зэрэг сэдвүүд багтсан нь үүнийг энгийн зүйл гэдгийг ойлгуулах, ялгаварлан гадуурхалттай тэмцэх зорилготой байв (БШУЯ, 2019). Энэ нь ЛГБТ төв ба “Бүх нийт боловсролын төлөө!” Иргэний нийгмийн үндэсний эвслийн бодлогын нөлөөллийн үр дүн байсан гэж хэлж болно. Гэсэн хэдий ч тухайн багш нар эрүүл мэндийн хичээлээр бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаа илэрхийлэлтэй холбоотой сэдвүүдийг заах арга барил эзэмшсэн эсэх нь тодорхойгүй бөгөөд тус хөтөлбөрийг эргэн нэвтрүүлснээс хойш эрүүл мэндийн хичээлийн чанарыг баталгаажуулах зорилгоор ямар нэгэн хяналт, үнэлгээг туйлын бага хийжээ. Цаашлаад суурь боловсролын хөтөлбөрийн өөр ямар ч хичээлд бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаа илэрхийлэлтэй холбоотой агуулга өнөөг хүртэл ороогүй байна.

ХУУЛЬ ЭРХЗҮЙ, БОДЛОГО

Монгол улс 2015 онд түүхэн гэж хэлж болох шинэ Эрүүгийн хуулийг баталсан бөгөөд ялгаварлан гадуурхах гэмт хэргийг эрүүгийн хэрэгт хамааруулж, бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаа илэрхийллийг хамгаалан зүйлчилсэн нь 2017 оны 7 дугаар сараас хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн. Гэсэн хэдий ч хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудлуудыг анхаарах, мөн хууль хэрэгжүүлэх байгууллагын хүний нөөцийг чадавхжуулах шаардлага байсаар байна. Цагдаагийн Ерөнхий Газрын тайлан мэдээгээр 2021 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар хууль хэрэгжиж эхэлснээс хойш тус хуулийн 14 дүгээр зүйлтэй холбоотой ердөө гуравхан тохиолдол бүртгэгдсэнийг Цагдаагийн Ерөнхий Газар хэрэгсэхгүй болгосон байна (ЛГБТ Төв, 2022). Түүнчлэн Монгол улс 2008 онд Иргэний бүртгэлийн хуульд нэмэлт өөрчлөлт оруулснаар транс болон интерсекс хүмүүсийн хувьд бичиг баримт дээрх хүйсийн тэмдэглэгээгээ өөрчлөх үйл явц харьцангуй хялбар болсон юм. Гэвч энэхүү хуульд 2018 оны 8 дүгээр сард дахин шинэчлэгдэн батлагдаж, иргэд хүйсийн хувьд “бүрэн” шилжилт хийснээ нотлох баримтаар батлах шаардлагатай болсон нь хуучин хуультай харьцуулахад илүү дордуулсан зүйл заалт болсон гэж хэлж болно. Ингэснээр Монгол улс трансжендер, интерсекс хүмүүсийн эрхийг хамгаалах чиглэлд арагш ухарсан хэмээн дүгнэж болох юм. Цаашилбал, дотоодын эрүүл мэндийн эмчилгээ,

үйлчилгээний тогтолцоонд транс хүмүүст зориулсан хүйсийн шилжилттэй холбоотой ямар нэг үйлчилгээ, стандарт огт байхгүй бөгөөд энэ нь транс болон хүйсийн хэвшмэл байдалд үл багтах хүмүүс дээрх хуулийг хэрэглэх боломжгүй нөхцөл байдалд хүргэж байгаа юм. 2018 оноос хойш өнөөдрийг хүртэл ЛГБТ Төвөөр дамжуулан энэхүү хуулиар хүйсийн тэмдэглэгээг өөрчилж чадсан ганц л хүн бий бөгөөд тухайн иргэн гадаад улсад зорчиж, нотлох баримт бүрдүүлсэн аж (ЛГБТ Төв, 2022). Түүнчлэн 2021 оны 7 дугаар сард Хөдөлмөрийн хуульд нэмэлт өөрчлөлт орсноор хүнийг ажлын байранд нь бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаа илэрхийллээр нь шууд болон шууд бусаар ялгаварлан гадуурхахыг хориглосон (Хөдөлмөрийн тухай хууль, 2021). Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн шинэчилсэн найруулга 2021 оны 12 дугаар сард батлагдсан. Тус хуулиар хүний эмзэг мэдээллийг цуглуулах, боловсруулах, ашиглахыг хориглосон бөгөөд хүний эмзэг мэдээлэл гэсэн тодорхойлолтод бэлгийн чиг баримжаа болон хүйсийн баримжаа багтсан байна (Хүний хувийн нууцыг хамгаалах тухай хууль, 2021).

Монгол улсын Үндсэн хуулийн 14 дүгээр зүйлийн 2-т “хүнийг ялгаварлан гадуурхаж үл болно”, мөн 16 дугаар зүйлийн 7-д хүн бүр сурч боловсрох эрхтэй хэмээн заасан ч эдгээр хуулийн зүйл заалтуудад бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаа илэрхийллийн тухай тодорхойлон тусгаагүйгээс бэлгийн болон хүйсийн цөөнх болсон иргэдийн хувьд эрх нь зөрчигдсөн нөхцөлд үндсэн хуулиар хамгаалуулах боломж нь хязгаарлагдмал байгаа юм. Монгол улс НҮБ-ын Хүний эрхийн есөн үндсэн гэрээний наймд нь элсэн орсноос гадна хүний эрхийн бусад гэрээ хэлэлцээрт нэгдсэн байдаг. Үндсэн хуулийн 10 дугаар зүйлд “Монгол Улс олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ, зарчмыг баримтална”, “олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлнэ”, түүнчлэн соёрхон баталсан олон улсын гэрээ, конвенцын тухай “соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ” хэмээн заасан байдаг. Цаашлаад олон улсын гэрээ, хэлэлцээрийн хүрээнд, Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 26 дугаар зүйлийн 1-д “Хүн бүр сурч боловсрох эрхтэй... Авьяас чадвартай нь уялдан хүн бүрд дээд боловсрол эзэмших эрх адилхан хүртээлтэй олгох ёстой” хэмээсэн бол мөн зүйлийн 2-т “Боловсрол нь бие хүнийг өв тэгш хөгжүүлэх, хүний эрх, үндсэн эрх чөлөөг улам бүр хүндэтгэдэг болоход чиглэх ёстой” хэмээн тусгажээ.

Мөн бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаа илэрхийлэлтэй холбоотой улс орнуудын хүлээх үүрэг, олон улсын зарчмуудыг багтаасан Жогжакартын Зарчмууд хэмээх баримт бичгийн 16 дугаарт “Хүн бүр бэлгийн чиг баримжаа, эсвэл хүйсийн баримжаа илэрхийллээсээ үүдэн, эсвэл эдгээрт хамаатай учир шалтгаанаар ялгаварлан гадуурхалтад өртөлгүй сурч боловсрох эрхтэй” хэмээн заасан байдаг. Гэсэн хэдий ч Монголын боловсролын тогтолцооны хууль эрхзүй, зохицуулалтад бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаа илэрхийллийн талаар тусгагдсан зүйл саяхныг хүртэл байхгүй байсан. 2022 оны 12 дугаар сарын 22-нд батлагдсан Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургалтын байгууллагын багш, ажилтны мэргэжлийн ёс зүйн дүрэмд багш, хүүхэд, эцэг эх зэрэг боловсролын харилцаанд оролцогчдыг бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаа, илэрхийллээр шууд ба шууд бусаар ялгаварлан гадуурхахыг хориглосон заалт туссан (БШУЯ, 2022).

Энэ нь Хүүхдийн Эрхийн Хорооноос 2017 оны 6 дугаар сарын 2-ны өдөр зохион байгуулсан Тавдугаар хурлаас гаргасан тайланд Монгол улсад ЛГБТИК+ хүүхдүүдийн нөхцөл байдлыг сайжруулах чиглэлээр тусгайлан хоёр зөвлөмж өгсөн байдаг (НҮБ, 2017). Түүнийг сийрүүлбэл:

- 1. Хорооны зүгээс тус улсад тэгш бус байдал өсөн нэмэгдсээр байгаад, ялангуяа орлого багатай өрхийн, шилжин суурьшсан, бүртгэлгүй, хөгжлийн бэрхшээлтэй, үндэсний цөөнх, өөр хэлтэй, уугуул иргэдийн болон гей, лесбиян, трансжендер (ЛГБТ) гэх мэт эмзэг, хүнд нөхцөлд байгаа хүүхдүүд ялгаварлан гадуурхалтад өртөж буйд, ялангуяа сургууль, дотуур байрны орчинд тэрхүү ялгаварлан гадуурхах үйлдлүүдэд хариуцлага тооцогдохгүй байгаад харамсаж байна.*
- 2. Хүүхдүүдэд, ялангуяа охид, эмзэг нөхцөлд байгаа хөгжлийн бэрхшээлтэй, ЛГБТ хүүхдүүдийг гэр бүл, орон нутаг, сургуулийн үйл ажиллагаанд утга учиртай, өөртөө итгэлтэй оролцоход туслах зорилгоор хөтөлбөрүүд хэрэгжүүлж, энэ талаар ойлголт нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулах хэрэгтэй.*

гэсэн байна.

ХОЁРДУГААР БҮЛЭГ:

Судалгааны дизайн

- Тус чанарын судалгааны тоо баримтыг ганцаарчилсан ярилцлагын аргаар цуглуулсан болно.
- “Транс Зөвлөлдөх Бүлэг”-ээс тус олон нийттэй холбоотой зөвлөмжөөр ханган ажилласан.
- Сургуулийн орчин болон сэтгэцийн эрүүл мэнд, түүнд нөлөөлөх хүчин зүйлсийг хянан судалсан болно.

ТРАНС ЗӨВЛӨЛДӨХ БҮЛЭГ

Судалгааны багийн гишүүд судалгааны ажлын загвар гаргах, хэрэглэх үг хэллэг, нэр томъёог тодорхойлох болон ярилцлагын асуултууд боловсруулахдаа тус нийгмийн бүлгийг төлөөлөн ажиллаж, нөлөөлөл хийж буй транс болон хүйсийн хэвшмэл байдалд үл багтах хүмүүстэй (хүүхэд залуус ч мөн багтана) ойр нягт хамтран ажилласан болно. Энэхүү Зөвлөлдөх бүлэг нь судалгаанд оролцогчид болох транс сурагчидтай ёс зүйн мэдрэмжтэй, хүндэтгэлтэй харилцаж, судалгааны ажлыг хүртээмжтэй болгоход амин чухал үүрэг гүйцэтгэсэн билээ.

ТРАНС ЗӨВЛӨЛДӨХ БҮЛГИЙН ГИШҮҮД:

Энхболдын Энхмаа – ЛГБТ Төвийн Гүйцэтгэх Захирал

Д. Мөнхнасан – “Саяана Энх Оршихуй” Трансжендер эмэгтэйчүүдийн холбоо

Ганзоригийн Энхжин – Трансжендер эрчүүдийн уулзалтын бүлгийн зөвлөх

Мөнхбатын Өүлэн - ЛГБТ Төвийн залуучуудын хөтөлбөрийн зохицуулагч

СУДАЛГААНЫ АРГАЗҮЙ

Бид энэхүү судалгаандаа олон оролцогчтой кейс цуглуулгын аргыг хэрэглэсэн бөгөөд энэ нь транс болон хүйсийн хэвшмэл байдалд үл багтах сурагчдын ердийн амьдралыг гүн гүнзгий таних мэдэх зорилготой. Бид транс болон хүйсийн хэвшмэл байдалд үл багтах хүүхэд залуусын сургуулийн болон сургуулийн гаднах орчинд өдөр тутмын амьдралдаа амсаж түүлж буй амьдралын туршлагын талаар ийнхүү мөшгөн судлахдаа нарийвчлан боловсруулсан ганцаарчилсан ярилцлагын аргыг хэрэглэлээ.

Ярилцлагад долоон оролцогч оролцсон бөгөөд ярилцлага тус бүр нэг цагийн хугацаатай, оролцогчийн сонгосон газарт өрнөсөн. ЛГБТ Төвийн сайн дурын ажилтны өрөөг аюулгүй, тайван орчин бүрдүүлэх зорилгоор оролцогч тус бүрд санал болгож байв. Хүйсийн баримжаа илэрхийллийнхээ талаар эцэг эхтэйгээ нээлттэй ярилцаж ил гараагүй учраас аюулгүй, тайван орчин бүрдүүлэх нь ярилцлагын оролцогчдын хувьд эцэг эхийн оролцоогүйгээр өөрийн амсаж туулж буй амьдралын туршлагын талаар ярилцахад нэн чухал үүрэгтэй байв. ЛГБТ Төвийн тус өрөөг судлаачид цагийн хуваарийн уян хатан нөхцөлөөр хэрэглэх боломжтой байсан тул зарим оролцогчтой бид оройн цагаар ярилцсан болно.

ОРОЛЦОГЧИД БОЛОН ТҮҮВЭРЛЭХ АРГА

Тус чанарын судалгааны оролцогчид нь 16-18 насны өөрийгөө транс болон хүйсийн бусад олон янз байдлаар илэрхийлдэг хүүхэд залуус байв. Нийт долоон транс сурагч энэхүү судалгаанд оролцож дэлгэрэнгүй, ганцаарчилсан ярилцлагаар дамжуулан өөрсдийн туулж буй амьдралын туршлагыг хуваалцсан болно.

Бид ЛГБТИК+ олон нийтийн харилцаа холбооны сүлжээ болон snowball буюу цасан бөмбөг хэмээх аргачлалаар судалгаанд оролцогчдыг сонгож холбоо тогтоосон билээ. Транс олон нийт нь Монголд хамгийн ихээр гадуурхагдан орхигдсон нийгмийн бүлэг бөгөөд эндээс насанд хүрээгүй оролцогчдыг дээжлэн сонгох нь хүнд сорилт байв. Тиймээс ч цасан бөмбөг хэмээх аргачлал буюу ярилцлагад оролцсон оролцогч нь өөрийн танилын холбоогоор дамжуулан дараагийн оролцогчийг санал болгох нь энэхүү судалгаанд тохиромжтой байв.

СУДАЛГААНД ЭЛСҮҮЛЭХ

Судалгааны хүрээнд бид өргөн хүрээний аргуудыг хэрэглэсэн. Зөвлөлдөх бүлгийн гишүүд өөрсдийн холбоо харилцаагаар дамжуулан энэхүү судалгааны ажил, түүний ач холбогдлын талаарх мэдээллийг түгээсэн. Нийгмийн сүлжээ, тэр дундаа Инстаграм, Фэйсбүүк зэрэг платформуудыг оролцогчид элсүүлэхэд голлон хэрэглэж байв. ЛГБТ Төвөөс инстаграм, фэйсбүүкийн платформд зориулсан зар түгээх постер бэлтгэж, өөрийн болон олон нийтийнхэнд зориулсан хаалттай фэйсбүүк группүүдэд нийтэлж тусалсан болно.

Судлаачид цасан бөмбөг арга зүйг зарим оролцогчийг элсүүлэхэд хэрэглэсэн бөгөөд багаар бодоход хоёр оролцогч энэхүү аргачлалын тусламжтайгаар ярилцлагад оролцсон. Бид ярилцлага өгсөн оролцогчдод тус судалгааны ажлыг өөрийн найз нөхдөд танилцуулахыг, мөн судалгааны багийнхантай, аль эсвэл ЛГБТ Төвийн гишүүдтэй нэг цагийн хугацаатай ярилцлага хийх боломжтой оролцогчийг санал болгохыг хүсэж байлаа.

ГАНЦААРЧИЛСАН ЯРИЛЦЛАГА

Ярилцлагуудыг судалгааны багийн гишүүн нэг цагийн хугацаатай оролцогч нэг бүртэй ганцаарчлан ЛГБТ Төвийн сайн дурын ажилтны өрөөнд хийсэн болно. Насаар бага оролцогчид өөр ямар нэг газар уулзаж ярилцахаас ЛГБТ Төвд ирэхийг илүүд үзэж байв. Ярилцлагаас өмнө оролцогчдод судалгааны ажил, түүний зорилгын талаар энгийн ойлгомжтой өгүүлбэрээр бичигдсэн танилцуулгыг тараан өгсөн. Тэрхүү танилцуулгыг уншиж танилцаад, түүнийг дагалдаж буй ярилцлага хийхийг зөвшөөрсөн Зөвшөөрлийн хуудаст гарын үсэг зурах хэрэгтэй гэдгийг оролцогч бүрд тайлбарласан. Түүнчлэн ярилцлага өгөх үйл явц бүхэлдээ сайн дурын хүсэл эрмэлзэл дээр тулгуурласан агаад оролцогчид судалгааны үйл явцын аль ч шатанд гарын үсэг зурсан зөвшөөрлөөсөө татгалзах бүрэн эрхтэй гэдгийг мөн тайлбарлан мэдэгдсэн болно.

Ярилцлагын зааврыг ярилцлага эхлэхээс өмнө тараасан. Тус зааврыг сургуулийн орчинд транс сурагчдын үзэж туулж буй зүйлс, сургуулийн удирдлагаас ямар нэгэн тусламж авч чаддаг эсэхийг тодорхойлох зорилгоор загварчлан боловсруулсан. Сургууль болон сургуулиас гадуурх орчинд үзэж туулж буй сорилт бэрхшээл, гадуурхагдан тусгаарлагдаж буй байдлыг оролцогчид хэрхэн даван туулж байгааг, тэрхүү өөрийгөө хамгаалах механизм юу болохыг олж тодорхойлох зорилгоор судалгааны асуултуудыг загварчлан бэлтгэсэн юм. Цаашлаад энэхүү ярилцлагаар ЛГБТИК+ олон нийтийг нийгэмд нээлттэй багтаах, үүнтэй холбоотой активизмийн талаар оролцогчид юу мэдэрч, амсаж туулж явааг, мөн хүйс, бэлгийн чиг баримжаа, жендер болон хүйсийн баримжаа илэрхийлэлтэй холбоотой ойлголтуудын талаарх үзэл бодлыг нь танин мэдэх зорилготой байв.

ДАТА АНАЛИЗ

Дуу хураагуурт бичсэн ярилцлагыг үг бүрчлэн цаасанд буулгаж, англи хэл рүү хөрвүүлсэн болно. Нийт 7 цаг 40 минутын соронзон бичлэг бүхий 56 хуудас гар бичвэрийг ярилцлагын төгсгөлд бэлтгэв. Бид эдгээр ярилцлагад дурдагдаж буй асуудлуудын утгын нийтлэг шинжийг тайлбарлахдаа сэдэвчилсэн анализын аргыг хэрэглэсэн болно. Үндсэн болон тэнхлэгийн кодлол хийхэд 4 үндсэн сэдэв гарсан бөгөөд тэдгээр нь тус бүр өөрийн гэсэн дэд сэдвүүдтэй болно.

ЁСЗҮЙН АСУУДАЛ

Энэхүү судалгааны ажлыг удирдан явуулахад ёс зүйн чухал асуудлууд тулгарсан. Өмнө хийгдэж байсан чанарын судалгаанаас харахад Монголд амьдарч буй транс хүүхэд залуус сургуулийн орчинд дээрэлхэлтэд ноцтойгоор өртдөг, нийгмээс үзүүлж буй ялгаварлан гадуурхалт нь тэдний нийгмийн амьдрал, сэтгэц, бие махбодын эрүүл, аюулгүй байдалд сөргөөр нөлөөлж байдаг аж (Ганбаатар ба бусад, 2021). Сургуулийн орчинд болж тохиолдож буй зүйлсийг судлахын тулд бид 18-аас доош насны хүүхэд залуусыг энэхүү судалгаандаа оролцуулах нь чухал байв. Иймд тухайн оролцогчдыг эцэг эх нь мэдэхээс сэргийлэх зорилгоор эцэг эх, хууль ёсны асран

хамгаалагчаараа судалгаанд оролцохыг зөвшөөрсөн хуудаст гарын үсэг зуруулахыг шаардаагүй болно.

Судалгааны түршид оролцох эсэх зөвшөөрлийн талаар оролцогчдод бүрэн танилцуулж байсан бөгөөд ингэснээрээ судлаач, оролцогч хоёрын дунд харилцан зөвшилцөл судалгааны бүх шатанд байж, оролцогчийн татгалзах сонголт аль ч үед нээлттэй байх боломжийг бүрдүүлж байв. Бид оролцогчдын хувийн мэдээлэл нууцлалыг чандлан хадгалахыг тэргүүн зорилго болгож судалгааны бүх шатанд ямарваа нэг нэр дурдаж тэмдэглээгүй болно. Судалгааны тайланд оролцогчдын өөрсдийнх нь сонгосон нууц буюу хуурамч нэрийг хэрэглэсэн. Цаашилбал, ирээдүйд гарч болох эрсдэл, хор нөлөөг тооцож, ярилцлага эхлэхээс өмнө сөрөг хүчин зүйлийн протоколыг бэлтгэж, судалгааны дараа оролцогчдод тусламж шаардлагатай үед туслуулахаар ЛГБТ Төвөөс сургаж бэлтгэсэн ЛГБТИК+-д ээлтэй хоёр сэтгэл зүйчийг бэлдсэн болно.

СУДАЛГААНЫ ХЯЗГААРЛАГДМАЛ БАЙДАЛ

Тус кэйс цуглуулгын судалгаанд интернэтийн тогтвортой хэрэглээтэй, мэдээлэлд ойр оролцогчдыг нийслэл хотоос сонгон авсан болно. Тиймээс энэхүү хялбарчлан сонгосон дээж нь хүйсийн олон янз байдал бүхий соёлыг таньж мэдсэн, тэрхүү нийгмийн бүлэгтэйгээ илүү ойр харилцаа холбоо бүхий транс хүүхэд, залуусын төлөөлөл юм. Судалгаанд хөдөө, орон нутаг болон хотын захын хорооллын мэдээлэл авах боломж хязгаарлагдмал төлөөлөл оролцоогүй. Алслагдмал дүүрэг, аймаг, сумдын хүүхэд залуусын амсаж туулж буй амьдралын туршлага харилцан адилгүй тул тэдний амьдарч буй газар нутаг, нийгэм эдийн засгийн байдал, яс үндэс, хөгжлийн бэрхшээл, бэлгийн чиг баримжаа, шашин шүтлэг гэх мэт хүчин зүйлсийг огтлолцуулан транс олон нийтийн талаар илүү дэлгэрэнгүй судалгааг цаашид хийх хэрэгтэй.

ГУРАВДУГААР БҮЛЭГ:

Оролцогчид

ОРОЛЦОГЧДЫН ДЕМОГРАФИК

Нэр	Нас	Хүйсийн илэрхийлэл	Төлөөний үг	Сургууль
Жолие	17	Трансжендер охин	Эмэгтэй	Улсын сургууль
Хантүшиг	16	Нонбайнари	Төлөөний бүх үг	Улсын сургууль
Игги	17	Трансжендер хөвгүүн	Эрэгтэй	Улсын сургууль
Синди	16	Трансфеминин/нонбайнари	Эмэгтэй, тэд	Хувийн сургууль
Баяр	16	Трансжендер хөвгүүн	Эрэгтэй	Улсын сургууль
Кас	16	Трансжендер хөвгүүн	Эрэгтэй	Хувийн сургууль
Шинээ	18	Трансжендер охин	Эмэгтэй	Улсын сургууль

Судалгааны оролцогчид болох Улаанбаатар хотын өсвөр насны транс сурагчид зөвхөн ганцаарчилсан ярилцлагад оролцсон. Насны хувьд 16-18 насны хооронд бөгөөд долоон сурагчаас гурав нь (42%) өөрийгөө транс хөвгүүн, гурав нь (42%) транс охин, хоёр нь нонбайнари (28%) хэмээн өөрийгөө тодорхойлсон. Бүгд бүтэн цагаар сургуульд хамрагддаг ба 5 нь (72%) улсын, хоёр нь (28%) нь хувийн сургуульд суралцаж байв.


Хүйсийн баримжаа, илэрхийллийнхээ тухай ярих боломж олгоход өсвөр, залуу үеийнхний сэтгэлийн хат сайжирсан нь мэдэгддэг болсон (Singh, Meng, & Hansen, 2014). Транс сурагчдын хувьд өөрийн жендерийн талаарх ойлголт нь туйлын хувийн шинж чанартай, тиймдээ ч ямар нэг ангилалд харьяалуулан үзэх боломжгүйг харуулж буй юм. Тус судалгаанд оролцсон олон оролцогчдод өөрийн оршихуйн мэдрэмжийн нэгээхэн хэсэг болох хүйсийн баримжааны талаар тодорхойлон ярих боломж олгосон билээ. Тэдний нэг Хантүшиг (нонбайнари, 16 настай):



Хантүшиг

(нонбайнари, 16 настай):

Эхэндээ би өөрийгөө транс эрэгтэй гэж боддог байсан. Цаг хугацаа өнгөрөхийн хэрээр өөрийн хүйсийн баримжаанд эргэлзэхийн зэрэгцээ би ч бас бусад өсвөр насны хүүхдүүдийн нэгэн адил өөртөө итгэлгүй байдал мэдэрдэг юм байна гэдгээ ойлгосон. Жаахан том болоод өөрийн биед дургүйцэх нь багасаж, нонбайнари байх нь илүү таатай санагдаж эхэлсэн, өөрийгөө аль нэг хүйст багтааж үзэхгүй гэсэн үг. Өөртөө ямар шошго зүүх нь тийм чухал биш, би зүгээр л хүн, хүүхэд, аль эсвэл зүгээр л Хантүшиг шүү дээ.



ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ:

Сургууль

Сургууль бол зөвхөн боловсрол олгох газар биш бөгөөд хүүхдийн хувьд аюулгүй, халуун дулаан, найрсаг орчин байх ёстой (Horowitz болон Hansen, 2008). Сургууль нь суралцагч бүрийн хувьд тэгш, шударга байдал, халамж анхаарал, мэдрэмжтэй байдал, хамт олон, багш-сурагчийн эерэг таатай харилцаа холбоог өөртөө багтаасан эрүүл уур амьсгалтай байх ёстой (Noddings, 2005). Боловсролын систем бүхэлдээ сизнормативд³ суурилан бүтээгдсэн учир дээр дурдсан бүхэн Монголын транс сурагчдын хувьд биеллээ олоогүй байдаг. Сургууль бол сизжендер⁴ буюу транс биш сурагчдын хувьд л ээлтэй орчин болохоос транс сурагчдын хувьд тийм биш. Фохард Доурлент⁵ (2016) нэгэнтээ “Сургууль өөрсдийг нь хүлээн зөвшөөрсөн байдлаар зохион байгуулагдсан болохоор ямар сурагчид хэзээ ч тэмцэх шаардлагагүй байдаг вэ?” хэмээн асуусанчлан сургуулийн уур амьсгал транс хүүхдүүдэд хэзээ ч зориулагдаагүй ба эерэг ээлтэй байх эсэх нь транс сурагчдаас өөрсдөөс нь бүхэлдээ хамаардаг бөгөөд тэдний хувьд хүйсийн баримжаагаа илэрхийлэн амьдарч, системчилсэн ялгаварлан гадуурхалт, эсэргүүцэн хавчих соёлын эсрэг ганцаараа тэмцэхээс өөр арга байдаггүйг боловсролын орчинтой холбоотой бараг бүх судалгааны бүтээлд дурдсан байна.

Монголын хувьд ерөнхий боловсролын сургуулиуд транс сурагчдад ээлтэй бус, найрсаг бус уур амьсгалтай. Судалгаанд оролцсон сурагчдын мэдэгдсэнээр тэд сургуулийн орчинд бүх зүйлийг хүйсээр ангилан хуваасан байдагт, анги хамт олон, багш сурган хүмүүжүүлэгч, сургуулийн захиргаа ямар нэг байдлаар тэднийг огт ойлгож дэмждэггүй зэрэгт туйлын ихээр гутарч зовниж явдаг ажээ. Бид оролцогч нэг бүрээс “Сургуульд транс сурагч байхын хамгийн хэцүү зүйл нь юу вэ?” хэмээсэн ижил асуултыг асуухад хүйсээр ангилан хуваасан ээлтэй бус сургуулийн орчин, анги танхим, материаллаг бааз, сургалтын хөтөлбөр болон багш нарын хандлага зэргийг хамгийн түгээмэл тулгамддаг бэрхшээлээр нэрлэж байв. Энэ бүхнийг бид дор дэлгэрүүлэн авч үзэх болно.

ХҮЙСЭЭР АНГИЛАН ХУВААХ СОЁЛ

Соёлын хувьд нийтлэг сизнорматив болон хүйсийг эр, эм хэмээн хоёр хувааж үзэх уламжлалт хандлага улсын боловсролын системд далд оршин байдаг. Боловсролын систем нь нийгэм дэх олон янз байдлын талаарх олон нийтийн тоомжиргүй байдлыг өөгшүүлэхийн зэрэгцээ, хүний эрхийн суурь ойлголтгүй, ялангуяа транс иргэдийн

3 Хүний төрөх үед тэмдэглэсэн хүйс нь хүйсийн баримжаатай нь тохирох үед хэрэглэдэг нэр томьёо

4 Хүний төрөхөд тэмдэглэгдсэн хүйс нь хүйсийн баримжаатай нь тохирох үед хэрэглэдэг нэр томьёо; трансжендер биш.

5 Frohard - Dourlent

эрхийн талаар ойлголт мэдрэмжгүй байдлын тусгал болсон гэж хэлж болно. Сургалтын материаллаг баазаас эхлээд өдөр тутмын сургалтын үйл ажиллагаанд хүйсээр ангилан хуваах соёл улсын боловсролын системийн бүрдэл хэсэг бүрд ужгиран нэвчиж, сургалтын үйл ажиллагаагаар дамжин ил тод зохион байгуулагдсаар байдаг.

Кас (транс хөвгүүн, 16 настай):

Сургууль дээр болдог зүйлсээс хамгийн хэцүү санагддаг нь сурагчдыг хүйсээр хуваах. Бараг л бүх зүйлд хүүхдүүдийг эрэгтэй, эмэгтэйгээр нь хуваах нь үнэхээр давчидмаар. Ангийнхан маань намайг эрэгтэй гэдгийг мэдэх ч багш нар мэдэхгүй, тиймээс би аль талд нь орохоо ч мэддэггүй... Ангид багш нар ямар нэг хэлэлцүүлэг ч юм уу өрнүүлэхдээ гэнэтхэн шийдээд л сурагчдыг хүйсээр нь хуваачихдаг.

Синди (транс охин, 16 настай):

Ингэх нь заримдаа надад хүйсээр илт ялгаварлаж байгаа юм шиг санагддаг. Энийг юу гэдэг билээ дээ, хөвгүүдийн зодолдож ноцолдохыг нь ерөнхийдөө хүлээн зөвшөөрдгийг? Хоёр долоо хоноход л 5-6 зодоон болдог, тэгснээ 5 минутын дараа тэд хоорондоо сайндчихна. Багшийн дэргэд ч тийм юм болно, үүнийгээ тэд хөвгүүдийн дунд байдаг л зүйл ч гэх юм уу нэг тийм балай юм хэлдэг... Мэдэхгүй юм. Хөвгүүд хараал хэлж, бусад хөвгүүдтэй хог новш шиг харьцчихаад эргэж хараад охидод эелдэг хандахыг байдаг л зүйл шиг хүлээн зөвшөөрдөг.

Жолие (транс охин, 17 настай):

Байгаагаараа, хэн гэдгээрээ сургууль дээр байх боломжгүй байх нь угаасаа хангалттай хэцүү санагддаг. Нэмээд сургууль дээр бараг бүх зүйлийг хүйсээр ангилан хуваадаг нь үнэхээр хэцүү. Технологийн хичээл гэхэд л хөвгүүд, охидод зориулсан хоёр тусдаа кабинеттай. Сургуулийн аяллаар явах боллоо гэж бодоход хөвгүүд, охидын бүлэг тус тусдаа байх жишээтэй. Тусдаа угаалгын өрөө, дүрэмт хувцас, зураг гээд л энэ жагсаалт дуусахгүй. Бүр өдөр тутмын ангийн ирц бүртгэлийг хүртэл хүйсээр хувааж тоолдог. Ер нь бүх л зүйлд хуваана.

ТЕХНОЛОГИ, БИЕЙН ТАМИРЫН ХИЧЭЭЛ

Судалгаанд оролцсон сурагчдын хувьд хүйсээр хамгийн их хуваадаг талбар бол Технологи, Биеийн тамирын хичээлүүд аж. Хүйсийн хэвшмэл ойлголт нь сургууль дээрх дээрэлхэлтэд хүчтэй нөлөө үзүүлдэг (Ганбаатар, 2021) бөгөөд хүйсээр ангилан хуваадаг биеийн тамирын хичээл зэрэг нь энэ төрлийн дээрэлхэлт, хүчирхийлэл байнга үйлдэгдэх талбар болж байдаг аж. Энэ нь транс сурагчдын сэтгэцийн эрүүл мэндэд сөрөг нөлөөтэй юм (Symons et al, 2014).

а) Технологи, зохион бүтээх хичээл

Энэхүү хичээл нь сурагчдыг хүйсээр ангилан хуваах тусгайлсан зохион байгуулалттай. Багш, сургалтын арга, хэрэглэгдэхүүн, хөтөлбөр, анги танхим хүртэл тус тусдаа хүйсийн хувьд салангид байхаар зохион байгуулагдсан байдаг. Игги (транс хөвгүүн, 17 настай)-гийн тодорхойлсноор “... технологийн хичээлээр охид, хөвгүүд хоёр тусдаа ангид хуваагдан орох хэрэгтэй болдог. Охид ихэвчлэн юм оёж, хоол хийдэг бол хөвгүүд багаж ашиглаж, ямар нэг юм бүтээх, инженерийн холбогдолтой зүйлст суралцдаг.” Энэхүү хичээл нь хүйсийн хэвшмэл ойлголтыг илтээр дэмжиж, сурагчдыг хүйсээсээ хамаарсан жендерийн уламжлалт үүргийг дагахад хүргэж байна. Технологи, зохион бүтээх хичээл нь хэрхэн жендерийн хэвшмэл хандлагыг үжгируулж, түүнчлэн эрэгтэй багш нар хичээлдээ бие махбодын хүчирхийлэл үзүүлэх замаар хортой эр жендерийн уламжлалт хандлагыг идэвхтэйгээр үлгэрлэж байгааг Жolie (транс охин, 17 настай) ийнхүү тайлбарласан юм.

Хөвгүүдийн технологийн хичээлийг туйлын хэвшмэл ойлголттой эрэгтэй багш заадаг. Тийм ч учраас хичээл хэвшмэл ойлголт хандлагаар дүүрэн. Багш нар эрэгтэй хүн ямар байх ёстой вэ гэсэн уламжлалт ойлголт, хандлагыг бидэнд тулгахын зэрэгцээ хэрхэн жинхэнэ эр хүн болох талаар заадаг гэхэд болно. Дунд ангид технологийн хичээлийн эрэгтэй багш нар хөвгүүдийн ар нуруу болон биеийн бусад хэсэгт цохидог байсан. Одоо ч хөвгүүд эрэгтэй багш нараар ийнхүү цохиулж л байдаг. Энэ үйлдлээ тэд нөгөө л нэг эр хүн зоригтой байж, хэд гурван цохилт даах чадвартай байх ёстой гэсэн хэвшмэл ойлголт, сэтгэлгээгээрээ зөвтгөдөг.

Илт хүйсээр ангилан хуваадаг тул транс сурагчдын хувьд технологийн хичээлд оролцох нь хамгийн хэцүү байдаг аж. Баяр (транс хөвгүүн, 16 настай) охидын кабинетад орох нь хэр бэрх байдаг талаар “Охидын кабинетад хичээл орох үед би зориуд хоцордог. Коридорт намайг тийш орж байгааг харах хүнгүй болсон үед л ордог. Завсарлагаагаар бүгд коридорт байх үед орж чадахгүй шүү дээ. Тийш орохыг минь бүгд гайхаж харцгаадаг. Эрэгтэй хүүхэд охидын кабинет руу орж явахыг бүгд гайхан харж байгааг би ясандаа тултал мэдэрдэг” хэмээн ярьсан юм. Тэрээр цааш үргэлжлүүлэн хүйсээр ангилан хуваасан хичээл хэрхэн сурагчдыг

суурь ур чадварт суралцахад саад болж, мөн нөөц боломжийг нь хязгаарлаж буй талаар “Би оёх дуртай, хувцасны загвар зохион бүтээгч болох хүсэлтэй. Хэдийгээр технологийн хичээлд дуртай ч охидын кабинет руу орохоос санаа зовоод байдаг. Сургууль яагаад оёх дуртай, хувцас загвар зохион бүтээгч болох хүсэлтэй хөвгүүдийг дэмждэггүй юм бол гэж гайхдаг. Надтай адилхан оёх дуртай, загвар зохион бүтээгч болох мөрөөдөлтэй эрэгтэй найзууд бий. Тэдний хувьд зүгээр л эрэгтэй учраас энэ бүхнийг сурч эхлэх боломж нь хязгаарлагдаж байгааг харах үнэхээр тэнэг санагддаг” хэмээн ярьсан юм.

в) Биеийн тамирын хичээл

Биеийн тамирын хичээлтэй холбоотой хамгийн түрүүнд дурдагдсан бэрхшээл бол хувцас солих өрөө юм. Сурагчид зааланд орохын өмнө хувцсаа сольж өмсдөг бөгөөд зарим сургуулиуд үүнд зориулсан хүйсээр ангилан хуваасан хувцас солих өрөөтэй байдаг. Тэрхүү хувцас солих өрөөнд хувцас сольж байсан хэмээн нэг ч сурагч хариулаагүй бөгөөд энэ нь тавгүйтэл, шоолуулах айдас, үе тэнгийнхэндээ өөр хүйстэй хэмээн хэлэгдэхээс болгоомжилсных аж. Үүний оронд тэд ариун цэврийн өрөөнд эсвэл ангидаа хувцсаа сольж өмсдөг, аль эсвэл дүрэмт хувцасныхаа дотуур биеийн тамирын хувцсаа өмсөөд сургууль дээр ирдэг байна.

Шинээ (транс охин, 16 настай):

Хувцас солих болоход би зүгээр л ширээн доогуураа орчихдог, эсвэл биеийн тамирын хувцсаа дүрэмт хувцасныхаа дотуур өмсөөд ирдэг. Ийм болохоор би биеийн тамирын хичээлд дургүй. Охид, хөвгүүдэд зориулсан тус тусын хувцас солих өрөө байдаг ч би орж үзээгүй. Бурхан минь, хэрэв тийш орвол юу болохыг би төсөөлж ч чадахгүй нь. Ангийнхан маань тэнд хувцсаа сольдог ч би шагайдаг ч үгүй, ядаж аль өрөө рүү нь орохоо ч мэдэхгүй байна. Тийм болохоор биеийн тамирын хичээлд бараг ордоггүй.

Кас (транс хөвгүүн, 16 настай)

Биеийн тамирын хичээлийн хувьд би байнга тасалдаг. Заалны хичээлд дургүй, биеийн тамирын багш нь ч онцгүй. Биеийн тамирын хичээлээр өгдөг дасгал, даалгавруудын хувьд эрэгтэй хүүхдүүдийн хийдгээс бага хийдэг болохоор транс эрэгтэй миний хувьд амар байдаг. Шалгалтын үеэр охидод арай бага даалгавар өгдөг. Хувцасны хувьд би биеийн тамирын хувцсаа дүрэмт хувцасныхаа дотуур өмсчихдөг. Эмэгтэй хувцас солих өрөөнд орох эвгүй, нүцгэн охидыг харах хэцүү санагддаг.

Энэхүү судалгаанд оролцсон транс сурагчид хүйсээр ангилан хуваасан зохион байгуулалттай тул биеийн тамирын хичээлд дургүй гэдгээ илэрхийлж байв. Багш

нарын сөрөг хандлага, хувцас солих өрөө, спорт дахь хүйсээр ялгасан дасгалжуулалт нь транс сурагчдыг спортод оролцоход бодит саад болж байна. Эдгээр бэрхшээл нь транс сурагчдын өөртөө итгэх итгэлд хүчтэй нөлөөлж, биеийн тамирын үйл ажиллагаанд оролцох хүсэл сонирхлыг нь бөхөөж байдаг аж.

Баяр (транс хөвгүүн, 16 настай):

Биеийн тамирын хичээл дээр өндрөөс нь нам хүртэл жагсаадгийг би ёстой үзэн яддаг. Өмнө нь охид хөвгүүдийг хүйсээр нь хуваалгүй жагсаадаг байсан. Сүүлийн 2 жил ингэхээ болиод эрэгтэй, эмэгтэйгээр нь хуваадаг болчихсон. Биеийн тамирын багшаас айдаг болохоор би хөвгүүдтэй хамт зогсмоор байсан ч охидын эгнээнд зогсдог. Бас спортоор өрсөлдөх надад хэцүү санагддаг. Гар бөмбөг, сагсан бөмбөг тоглох дуртай ч хөвгүүдийн багт орох боломжгүй болохоор тогломоор санагдвал охидын багт орохоос өөр аргагүй болдог. Өнгөрсөн жил би сагсан бөмбөгийн багт орохыг хүссэн ч тэгээгүй, яагаад гэвэл зөвхөн охидын багт л тоглох боломжтой байсан.

Жолие (транс охин, 17 настай):

Биеийн тамирын хичээл бол бүр үнэхээр ярих ч юм биш. Охидыг гар дээр 15 сунналгадаг бол хөвгүүдийг 35 гэх мэт. Би гар дээр суннаж чаддаггүй. Хөвгүүд шиг дасгал хийж, тэдэн шиг байж чадахгүй. Зааланд хичээл орсон үед богино өмд ч юм уу өөр хүссэн зүйлээ өмсөх боломжгүй. Хэрэв би богино өмд өмсчихвөл хүн болгон намайг “Юу өмсчихөө вэ, чи яагаад ийм охин шиг юм бэ?” гэгцгээн шоолж, хүйсээр минь ялгаварлан гадуурхана. Охид зүгээр юу ч хийхгүй зогсож байхад хөвгүүдийг гар дээр сунналгаж шийтгэнэ. Охид волейбол тоглох ёстой байдаг бол хөвгүүд сагсан бөмбөг. Би уг нь волейбол тоглох дуртай ч тэдний хувьд би эрэгтэй хүүхэд учраас хөвгүүдийг дагаж сагс тоглохоос өөр аргагүй болдог. Үргэлж л сурагчдын дуртай спортоороо хичээллэх хүсэл зоригийг хясаж байдаг.

ДҮРЭМТ ХУВЦАСНЫ ЖУРАМ

Монголд сургуулиуд хүйсээр ангилан хуваасан дүрэмт хувцасны хатуу журам мөрдөхийг сурагчдаас шаарддаг, үсний засалт ч үүнд багтана. Тулган мөрдүүлдэг энэхүү журам нь транс сурагчдад хүндээр тусдаг. Транс хөвгүүд богино банзал өмсөж, үсээ ургуулах хэрэгтэй байдаг бол транс охидын хувьд эсрэгээрээ (Ганбаатар, 2021). Хувийн сургуулиудтай харьцуулахад Монголд улсын сургуулиуд хувцаслалтын илүү хатуу бодлого баримталдаг.

Судалгаанд оролцогчдын хариулснаар цаг уурын нөхцөл байдал ямар байгаагаас үл хамааран охид өдөр бүр богино банзал өмсөх хэрэгтэй байдаг ба дүрэмт хувцасны дор, эсвэл дээгүүр ямар нэг өөр хувцас өмссөн эсэх, зохих ёсоор хувцасласан эсэхэд

ахлах ангийн сурагчдаас бүрдсэн баг хяналт тавьдаг байна. Хэрэв тухайн сурагч долоо хоногт хоёроос илүү зөрчил гаргавал сарын эцэст сурагчдын зөвлөлийн хурлаар түүнийг авч хэлэлцдэг аж. Харин хувийн сургуулиуд хувцаслалтын хувьд харьцангуй уян хатан ханддаг. Охид өмд өмсөж, хөвгүүд төрөл бүрийн үс засалттай байх боломжтой.

Игги (транс хөвгүүн, 17 настай):

Охид байнга богино юбка өмсөх ёстой. Бүр үс засалт ямар байх ёстой талаар тогтсон журамтай. Жишээлбэл, хөвгүүд үсээ ургуулж, будаж, бас хааш яаш үс засалттай байж болохгүй, харин охид халимаг үстэй байж болохгүй, үсээ үргэлж боох ёстой. Би өмд өмсөхийг үргэлж хүсдэг. Дунд ангид нэг хэсэг өмд өмссөн. Тэр үед сургууль энэ үйлдлийг минь дүрэмт хувцасны журмыг ноцтой зөрчсөн гэж үзэн сурагчийн үнэмлэхийг минь цоолж нүх гаргаж байсан. Тэгээд би өмд өмсөх боломжгүй болж байнга юбка өмсөх болсон. Жижүүрт гарч байгаа ахлах ангийнхан сурагчдын иймэрхүү зөрчлийг бүртгэдэг. Сурагчийн үнэмлэхээ хоёр болон түүнээс дээш удаа цоолуулсан сурагчийг хурлаар оруулж, дахиж зөрчил гаргахгүй гэсэн амлалтыг нь авдаг. Сурагчдын хувьд энэ нь нэг тийм ичгэвтэр зүйл гэж би хэлнэ. Сурагч бусад олон сурагчийн өмнө гарч зогсоод “Би дахиж ямар нэгэн зөрчил гаргахгүй” гэсэн амлалт өгдөг юм.

Кас (транс хөвгүүн, 16 настай):

Манай сургуулийн [хувийн сургууль] дүрэмт хувцас ердөө цагаан цамц, цэнхэр хантааз. Охид өмд, юбоканы алийг нь ч өмсөж болно, гэхдээ хөвгүүд юбка өмсөж болох эсэхийг мэдэхгүй юм. Ер нь л амар байдаг. Өмсмөөргүй санагддаг болохоор дүрэмт хувцсаа өмсдөггүй. Бид төгсөх анги болохоор дүрэмт хувцастай холбоотой асуудлаар шийтгүүлээд байдаггүй. Цагаан цамцаа өмссөн л бол болох нь тэр.

Транс сурагчид богино банзал өмсөхгүй, эсвэл үсээ ургуулснаасаа болж сургуулийн дүрэм журам зөрчсөн хэмээгдэн багш нарт байнга шийтгүүлдэг аж. Судалгааны оролцогчид, ялангуяа транс хөвгүүд богино банзал өмсөхийг “зэвүүцмээр” хэмээн тодорхойлж байв. Нас бага үедээ жендерийн хэвшмэл байдалд нийцүүлэх үүднээс хүчээр банзал өмсдөг байсан бол өсөж том болохын хэрээр өдөр тутмын дарамт шахалт, шийтгэлийг үл хайхран өмд өмсөж, үсээ богиносгон тайруулах болсон хэмээн тэд хариулж байсан юм.

Баяр (транс хөвгүүн, 16 настай):

Дүрэмт хувцас муухай, цамцнаасаа эхлээд л. Цамц нь хэт бариу, тайлаад шидчихмээр санагддаг. Юбка заавал өмсөх ёстой, өмсөх гэж бөөн зовлон. Миний хувьд дотуур нь өмд өмсчихдөг тэгээд боломж гарвал юбка тайлаад цүнхэндээ хийчихдэг. Дүрэмт хувцас бүрэн биш, жендерийн уламжлалт хэвшмэл хэв загвараас өөр үс засалттай байвал зөрчил гаргасан гэсэн хуудас өгдөг. Эхэндээ би байнга л шийтгүүлдэг байсан ч өмд өмсөөр л байсан. Тэд бодвол залхсан байх өнгөрсөн жилээс хойш намайг өмд өмсөхөд тоохоо больсон.

Дүрэмт хувцас, үс засалттай холбоотой сургуулийн дүрэм журам нь транс сурагчдын сэтгэцийн эрүүл мэнд, өөртөө итгэх итгэлд гүн гүнзгий нөлөө үзүүлдэг аж. Хувцаслалтаас үүдэн хүйсийн нийцэмжгүй байдлыг⁶ биеэрээ туулах бэрхшээлтэйн дээр багш, сургуулийн захиргааны зүгээс байнга загнаж, шийтгэх нь транс сурагчдын хувьд ихээхэн дарамт болдог байна. Тус судалгаанд оролцсон транс хөвгүүдийн хувьд эршүүд байдлаа илэрхийлэн өмд өмсөж, үсээ засуулах нь өөртөө итгэх итгэлийг нь сэргээж өгдөг гэсэн бол транс охид эмэгтэйлэг байдлаа илэрхийлэн богино банзал өмсөж, нүүрээ будвал багш нар болон үеийнхэндээ зэрлэгээр дээрэлхүүлэх болно хэмээн хариулсан юм.

Хантүшиг (нонбайнари, 16 настай):

Сургууль дээр юу өмсөх эсэхийг тухайн сургуулийн захиргаа шийддэг гэж би боддог. Сургууль охидыг заавал юбка өмсөхийг шаардахаар үнэхээр хэцүү. Дээд ангийн нэг охин өмд өмсдөг байсан юм. Би тэндээс зориг орж өмд өмсөж эхэлсэн. Үнэхээр гайхалтай сайхан санагдсан. Одоо би эрэгтэй цамц авсныгаа өмсөж эхэлнэ гэж бодож байгаа.

Баяр (транс хөвгүүн, 16 настай):

Анхандаа их хэцүү байсан. Бага ангид байхдаа би их доожоогүй хүүхэд байсан юм, яагаад гэвэл бусдаас өөр. Өсөж том болсон ч өнөө л доожоогүй хэвээр. Гэхдээ өнгөрсөн жил би үсээ засуултал жинхэнэ өөрчлөлт болж чадсан. Үсээ засуулсны дараа хүмүүсийн хандлага харьцангуй сайжирсан. Хуучин үс засалт маань ёстой новшийн байсан л даа, нүүр царайд минь ч зохидоггүй. Хүмүүсийн хандлага тэр даруй өөрчлөгдсөн нь би илүү дажгүй үс засалттай, өөрт минь зохисон эрэгтэй үс засалттай болсных гэдгийг би тэгж ойлгосон.

⁶ Төрөх үед тэмдэглэсэн хүйстэй тухайн хүний хүйсийн баримжаа нийцэхгүй байх төлөв байдал, тус нийцэмжгүй байдал нь сэтгэц, сэтгэлзүйн онцгой дарамт болдог.

Жолие (транс охин, 17 настай):

Би ч гэсэн юбка өмсөж биеийн галбираа харуулмаар байдаг. Даанч тэгж чадахгүй. Тиймээс эрэгтэй дүрэмт хувцас өмсөж, эрэгтэй хүн болж дүр эсгэхээс өөр аргагүй. Сургууль дээр нэг удаа би богино цамц, юбка өмсөж очсон. Бүгд над руу аймшигтайгаар харж байсан. Тэгээд зургийг минь дарж эхэлсэн. Бүгд бүр багш нар хүртэл намайг үг хэлээр харааж доромжилсон. Шоолж, нэг нь надаас түрүү булчирхайн шинжилгээ өгөөд ийм болчихоо юу гэж асууж даажигнасан.

АРИУН ЦЭВРИЙН ӨРӨӨ

Транс сурагчдад тулгамддаг асуудал бэрхшээлүүдийн ярвигтай, нарийн төвөгтэй байдал ариун цэврийн өрөө хэрэглэх тухай ярилцахад илүү тодорхой болж байлаа. Сургуулийн захиргаанд үүнтэй холбоотой мэдлэг ойлголт туйлын дутмаг. Өнөөг хүртэл сургуулийн орчныг транс сурагчдад ээлтэй болгох талаар улсын боловсролын системийн түвшинд нэг ч удаа авч үзэж, хэлэлцэж байгаагүй бөгөөд транс сурагчдын оршин байгааг Монголын боловсролын тогтолцоо, бодлого, сургуулийн захиргаа үл мэдэж, үл хайхарсаар иржээ. Хүйсээр ангилан хуваасан ариун цэврийн өрөөтэй холбоотой бэрхшээлүүдийн талаар Жолие (транс охин, 17 настай) тайлбарлахдаа аль өрөөг нь хэрэглэж болох эсэхээ мэдэхгүй эргэлздэг гэсэн юм. Тэрээр:

Ариун цэврийн өрөөний асуудал бол хамгийн дарамттай нь. Тийш ордог ч үгүй. Би өөрийгөө охин гэдгийг мэднэ, охин гэж мэдэрдэг. Гэсэн ч охидын ариун цэврийн өрөөнд ороход зайл гэж өөдөөс орилдог. Тэгээд хөвгүүдийнхэд ороход тэд инээлдэж, бүр илүү шоолж тавладаг. Тиймээс би яахаа ч мэдэхээ больсон. Сүүлийн үеийн хүүхдүүд арай илүү мэдлэгтэй болсон гэж найддаг ч ер тэгээгүй, үргэлж л тэнэг юм ярьж байдаг.

Жолиегийн нэгэн адил судалгааны бусад оролцогчид ч хүйсээр ангилан хуваасан ариун цэврийн өрөө хэрэглэх бэрхшээлийн талаар ярьж байв. Оролцогчдын хувьд тэрхүү бэрхшээл нь харилцан адилгүй байсан бөгөөд хэрхэн шийдэж ирснийг нь дор сийрүүлье.

Баяр (транс хөвгүүн, 16 настай):

Давхар болгон хоёр талдаа хоёр ариун цэврийн өрөөтэй, нэг нь эрэгтэй, нөгөө нь эмэгтэй гэж хуваасан. Охидын ариун цэврийн өрөөнд орсноос үхсэн нь дээр, хөвгүүдийнх рүү орвол зодуулна. Тиймээс шээхээ больсон нь дээр юм байна гэж би бодсон. Миний хувьд хөвгүүдийн ариун цэврийн өрөөнд орох хэцүү байдаг. Бүгд над руу хараад “Зайлаач ээ, чи энд юу хийж яваа юм? Чи чинь охин биз дээ?” гэж хашхирдаг. Тэгээд

би аль нэг бүхээгт нь өөрийгөө түгжиж байгаад хөвгүүд бүгд гарч явах хүртэл хүлээдэг. Бүгдийг нь гарахыг хүлээж байгаад заримдаа хичээлдээ хоцорч ордог доо.

Шинээ (транс охин, 16 настай):

Транс сурагч байна гэдэг олон талаар амаргүй. Хамгийн энгийн жишээ хэлэхэд л зөв ариун цэврийн өрөөгөө хэрэглэх тухай. Манай анги 6 давхарт байрладаг, охидын ариун цэврийн өрөө 6 давхарт, хөвгүүдийнх 5 давхарт байдаг. Би ихэвчлэн завсарлагааны бус цагаар хичээл орж байхад нууцаар охидын ариун цэврийн өрөөнд ордог. Арай зөөлөндүү багш хичээл орох үеэр “Ариун цэврийн өрөө орж болох уу, багш аа” гээд зөвшөөрөл аваад гардаг.

Зарим сургууль багш нарт зориулсан хүйсээр ангилан хуваагаагүй ариун цэврийн өрөөтэй ч, сурагчдад тийм өрөө байхгүй. Энэ нь хүйс заагаагүй ариун цэврийн өрөө бий болгох ямар амар болохыг харуулж буй хэрэг бөгөөд сурагчдын хувьд ч ингэж хийх боломжтой юм. Хүйс заагаагүй ариун цэврийн өрөө хэрэглэх хэчнээн амар байсан талаар Баяр (транс хөвгүүн, 16 настай) ийнхүү ярьсан юм.

Эмэгтэй хүүхэд шиг харагддаг байх үедээ би охидын ариун цэврийн өрөөнд ордог байсан. Мэдээж хэрэг ингэх нь надад хэзээ ч таалагдаж байгаагүй. Нүүрээ будаж байгаа охидтой хамт нэг ариун цэврийн өрөө хэрэглэх хачин санагддаг байв. Саяхнаас номын сангийн дэргэд багш нарт зориулсан шинэ ариун цэврийн өрөө гаргасан. Эрэгтэй, эмэгтэй аль алин нь орж болдог болохоор надад тийш орох нь хавьгүй амар байх болсон. Одоо бол би багш нарын хүйс заагаагүй ариун цэврийн өрөөнөөс өөр аль ч ариун цэврийн өрөөнд орохоо больсон. Хэн нэгэн нь намайг охин гэж хэлэх, надаар доог тохуу хийнэ гэж санаа зовохоо больсон. Багш нарын ариун цэврийн өрөө түгжээтэй үед би бага ангийн жигүүр рүү явдаг.

Ариун цэврийн өрөө хэрэглэхтэй холбоотой олон янзын бэрхшээлүүдээс үүдэн ихэнх транс сурагчид тийш орохоос зайлсхийж байхад транс биш сурагчид ариун цэврийн өрөөг үндсэн үүргээс нь өөр тамхи татах, нүүрээ будах, өөрөг дарах, хов жив ярилцах, хоорондоо харилцаа тогтоох гэх мэт олон зорилгоор ашиглах боломжтой байдаг. Хэдий хэцүү ч транс сурагчдын хувьд хувцас солих нь ариун цэврийн өрөө хэрэглэх өөр ганц шалтгаан юм. Хувцас солих өрөө хүйсээр ангилан хуваасан транс сурагчдын орохоос зүрхшээдэг, хэзээ ч ордоггүй бас нэгэн хэрэглэгдэхүүн тул тэдний ихэнх нь биеийн тамирын хичээлийн өмнө ариун цэврийн өрөөнд хувцсаа сольж өмсдөг. Тиймээс ариун цэврийн өрөө хэрэглэх нь, цаашлаад үг хэлээр доромжлуулах, зарим талаар бие махбодын хүчирхийлэлд өртөх боломжтой ийм газруудад байх нь транс сурагчдын сэтгэцийн эрүүл мэнд доройтоход нөлөө үзүүлэх гол хүчин зүйл болж байна гэж дүгнэж болно.

Баяр (транс хөвгүүн, 16 настай):

Миний хувьд эрэгтэй хувцас солих өрөөнд хэзээ ч орж чадахгүй. Бие махбод минь эмэгтэй ч гэлээ охидын хувцас солих өрөөнд орвол бүгд намайг хэн гэдгийг мэдэж байгаа болохоор охидын дунд байх эвгүй санагддаг. Өмнө нь би ариун цэврийн өрөөнд хувцсаа сольдог байсан ч, одоо бол ангийн хойд хэсэгт үлдэж байгаад хувцсаа сольчихдог болсон. Намайг хөвгүүдийн хувцас солих өрөөнд нүцгэлж байна гээд төсөөлөөд үз дээ. Бүгд шоконд орж үхэх биз.

Игги (транс хөвгүүн, 17 настай)

Охидын дэргэд хувцсаа солино гэдэг их эвгүй, тухгүй. Би тэнд байснаараа, эрэгтэй гэдгээ хэлэхгүй байгаагаараа тэдний хувьд ямар нэг буруу, муу зүйл хийж байгаа юм шиг санагдаад байдаг. Дүрэмт хувцасны цагаан цамцны дотуур богино ханцуйтай цамц заавал өмсдөг яагаад гэвэл би хоёр давхар спорт хөхний даруулга өмсдөг болохоор тэр. Үүнийгээ нуухын тулд би ариун цэврийн өрөөнд орж хувцсаа сольдог. Ариун цэврийн өрөөнд ороход бас л охидынх руу орох хэрэгтэй болно, тэгээд бас л охид байж таарна, тиймээс биеийн тамирын хичээлд орохын өмнө хувцсаа солино гэдэг маш хэцүү үйл явц болж хувирдаг.

СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР

Сурагчдын чөлөөтэй мэдээлэл хайх, хүлээж авах, хандах, хуваалцах боломжийг хангахад сургууль гол үүрэгтэй. Тус судалгааны үндсэн сэдэвтэй холбоотойгоор тэрхүү мэдээлэлд ЛГБТИК+, ялангуяа трансжендер хүмүүстэй холбоотой асуудлууд багтах ёстой хэмээн бид үзэж байгаа юм. Хүйсийн баримжаатай холбоотой сэдвүүдийг холбогдох хичээлийн хөтөлбөрт оруулж өгөх нь сурагчдыг энэ төрлийн мэдээллээр хангах эхний алхам болж чадна. Цаашлаад сургуулийн номын санг холбоотой мэдээллээр баяжуулж, хүйсийн олон янз байдлыг дэмждэг төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллаж болох юм. Сургуулийн захиргаа сурагчдын мөн чанарын олон талт байдлыг хүлээн зөвшөөрч, сургалтын хөтөлбөрөө сурагчдын бодит байдалтай уялдуулах нь тэдний идэвх оролцоог нэмэгдүүлж, сурлагын амжилтыг дээшлүүлэх үр дүнтэй (Shields, 2004).

Бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжааны талаар тусгаж өгсөн цорын ганц хичээл бол эрүүл мэндийн боловсролын хичээл юм. Ийнхүү оруулж өгсөн нь транс сурагчдад ээлтэй сургуулийн орчин бий болгох дэвшилтэт алхам болсон гэж хэлж болно. Судалгаанд оролцсон транс сурагчид бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжааны талаар хичээлээр дамжуулан сонсох нь өөрийн баримжаа илэрхийллийг ойлгоход дөхөм болохоос гадна, бусад сурагчдад асуудлаа тайлбарлан ойлгуулахад нэмэртэй байсан хэмээн хариулсан юм. Энэ нь яваандаа транс сурагчдад ээлтэй сургуулийн орчин бүрдэхэд дөхөм болох боломжтой гэсэн үг юм. Сургалтын хөтөлбөрөөр

дамжуулан өөрийн хэн гэдгийг ойлгож танихад дөхөмтэй байсан талаар Баяр хувийн туршлагаа ярьсан бол Хантүшиг тус эрүүл мэндийн хичээл нь бусад сурагчдад ЛГБТИК+ асуудлуудыг таньж мэдэх боломж олгож байсан тухай дурдсан юм.

Баяр (транс хөвгүүн, 16 настай):

ЛГБТ хүмүүстэй холбоотой асуудлыг ганцхан эрүүл мэндийн хичээлээр дамжуулан 9 дүгээр ангид заадаг. Одоо бодоход тэр хичээл намайг хэн гэдгээ таньж мэдэж, тодорхойлоход тусалсан юм уу даа. КОВИД-19 цар тахлын үеэр орсон цахим хичээл байсан юм. Багш тухайн хичээлийн сэдвээр слайд танилцуулга бэлтгэн бидэнд өгч боломжтой цагтаа үзэх даалгавар өгсөн юм. Би тэр хичээлийг уншиж байгаад энэ тухай цааш дэлгэрүүлэн уншихыг хүсвэл энэхүү холбоос дээр дарна уу гэсэн бичиг байхаар нь дартал ЛГБТ Төвийн цахим хуудас руу орсон. Тэнд байгаа бүх зүйлийг би нэгд нэгэнгүй баяртайгаар уншсан. Бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаа, тэдгээрийн тодорхойлолт, тохиромжтой нэр томъёо гээд маш олон зүйл байсан.

Хантүшиг (нонбайнари, 16 настай)

9-р ангийн эрүүл мэндийн боловсрол хичээлийн сурах бичигт ЛГБТ хүмүүстэй холбоотой сэдэв бий. Бэлгийн чиг баримжааг гетереосексуал, гомосексуал, бисексуал хэмээн ангилсан байдаг. Намайг стрэйт гэж хэлэхэд ангийнхан маань “Стрэйт гэдэг чинь гетереосексуал гэсэн үг биздээ, тээ?” гэх мэтээр асуудаг. Тэд энэ нэр томъёог сурах бичгээс сурсан байдаг. Бид бүгд л юу ч мэдэхгүй байж байгаад сурах бичгээс энэ бүхнийг сурсан. Харамсалтай нь хичээлийн хуваарьт эрүүл мэндийн боловсрол хичээл байсаар байхад багш нар тэр бүр заадаггүй, хичээлийг өөрийн хүслийн дагуу эсвэл юу дуртайгаа ярьж өнгөрүүлдэг. Хүртээмжтэй сургалтын хөтөлбөр чухал. Сурах бичигт багтаж орсон байна гэдэг нь тухайн мэдээлэл үнэн зөв гэдгийн баталгаа болж, төр, боловсролын систем үүнийг дэмжиж байгааг илэрхийлдэг. Тиймээс би өөрийн хүйсийн баримжааны талаар илүү өөртөө итгэлтэй ярьж, ангийнхандаа энэ талаар мэдээлэл өгөхөөс эмээдэггүй.

Синди (транс охин, 16 настай)

Сургалтын хөтөлбөр ЛГБТИК асуудлыг багтаасан байх нь маш чухал байлгүй яах вэ, миний л мэдэхийн манай ангид хоёр л хүүхэд күйр хүмүүст ээлтэй ханддаг. Бусдынх нь хувьд хэлэхэд хэцүү л дээ, олдмол гомофобитой⁷ болохоор. Хүүхдүүд яагаад гомофоби хандлагатай

⁷ Гомофоби гэдэг нь бэлгийн цөөнх хүмүүсийн эсрэг, тэднийг үзэн ядах үзэл юм.

байгаагаа ч мэддэггүй. Магадгүй энэ талаар боловсрол олговол үзэл бодол нь илүү тэлэх байх... Би маш олон сайн хүн мэднэ, гэхдээ тэд гомофоби хандлагатай. Магадгүй күйр⁸ асуудлыг багтаасан агуулга эрүүл мэндийн боловсрол, социологи, биологи зэрэг холбоотой хичээлүүдээр дамжуулан орвол нэмэр болох байх.

Зарим хувийн сургуулиуд улсын хэмжээний боловсролын хөтөлбөрийг сургалтын хөтөлбөртөө мөрддөггүй байна. Оролцогчдын зарим нь хувийн сургуулийн сургалтын хөтөлбөрөөр дамжуулан ЛГБТИК+ сэдэвтэй холбоотой ямар ч зүйл үзэж судалж байгаагүй хэмээн мэдэгдсэн юм.

Кас (транс хөвгүүн, 16 настай)

Манай сургуулийн сургалтын хөтөлбөрт ЛГБТИК-тэй холбоотой юу ч байхгүй. Бүр юу ч. Сургуулиас ЛГБТИК хүмүүстэй холбоотой юу ч зааж байгаагүй, бүр бэлгийн харилцааны тухай дурдаж ч байгаагүй. Аюулгүй байдлын хичээл гэж байхаас эрүүл мэндийн боловсролын хичээл гэж ер үгүй. Аюулгүй байдлын хичээлээр гал гарвал яах вэ, хэрхэн барилгаас гарах вэ гэх мэт зүйлсийг л заадаг. ЛГБТИК-тэй холбоотой ямар ч зүйл би хичээл дээр сонсож байгаагүй.

Хэдийгээр бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжааны тухай эрүүл мэндийн боловсролын хичээлийн хөтөлбөрт эргүүлэн суулгаж өгсөн ч заах аргазүйн хувьд 20 жилийн өмнөх үеэс өөрчлөгдсөн зүйлгүй хэвээр байна. Бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаатай холбоотой хичээлийн чанарын талаар транс сурагчидтай хийсэн энэхүү судалгааны үр дүн - багш нар бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаатай холбоотой сэдвийг ихэнхдээ орхигдуулдаг, заах аргазүйн чанарын хувьд асуудалтай, заримдаа багш нар гомофоби, трансфоби⁹ болон сөрөг хандлага харуулдаг хэмээсэн 2013 онд асуулгын аргаар явуулсан судалгааны хариутай яг адил байгаа юм. Эрүүл мэндийн боловсролын хичээлд зориулсан цогц сургалтын хөтөлбөр байсаар атал энэ хичээлд зориулсан цагийг ихэнх багш нийгмийн ухаан, математик, эсвэл биологи гэх мэт өөр хичээлд зориулдаг аж. Цаашилбал багш нар тус хичээлийг заахаар бэлтгэгдээгүй, заах чадамжгүй байдаг ба ихэнхдээ биологи, нийгмийн ухааны эсвэл биеийн тамирын багш нарт хавсран заах хичээл болгон хуваарилсан байдаг аж. Хэд хэдэн оролцогчдын хариулснаар багш нар бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаатай холбоотой сэдвүүдийг орхигдуулдаг хэвээр бөгөөд алгасалгүй өнгөрөх тохиолдолд ЛГБТИК+ хүмүүсийг өрөвдөх эсвэл илтээр эсэргүүцэх хандлага харуулдаг аж. Олонх багш эрүүл мэндийн боловсролын хичээлийг орхигдуулж, хичээлийн цагийг өөр зорилгоор ашигладаг учраас тус хичээл үндсэн зорилгоо алдаж, багш, сурагчдын аль алинд ямар ч хэрэггүй хичээлд тооцогдох болжээ.

8 “Күйр” гэдэг нь жендер болон бэлгийн чиг баримжааны зан үйлийн хувьд хэвшмэл байдалд багтдаггүй хүмүүсийг нэрлэдэг толгой нэр томьёо юм (Shlasko 2005). Сүүлийн үед залуу үе өөрсдийгөө болон адил бүлгийн хүмүүсийг ЛГБТИК+ хэмээх товчлолоор нэрлэхийн оронд энэ нэр томьёогоор тодорхойлохыг хүчтэй дэмжиж буй.

9 Трансфоби гэдэг нь хүйсийн цөөнх буюу трансжендер хүмүүсийн эсрэг, тэднийг үзэн ядах үзэл юм.

Шинээ (транс охин, 18 настай):

Эрүүл мэндийн боловсрол нэртэй хичээл байдаг. Энэ хичээлийг 6 дугаар ангиас эхлэн биднийг төгсөх хүртэл заах ёстой юм билээ. Би одоо 12 дугаар анги, удахгүй төгсөж элсэлтийн ерөнхий шалгалт өгнө... Долоо хоногт нэг удаа орох ёстой боловч эрүүл мэндийн боловсрол, иргэний ёсзүй гэх мэт хичээлийг багш нар зогсоож, бүх хүүхдэд автоматаар 100% гэсэн үнэлгээ өгсөн. Энэ хичээлүүд математик, нийгмийн ухааны хичээлүүд шиг чухал биш. Эрүүл мэндийн боловсрол, Иргэний ёс зүй гэсэн хичээлүүдийг заах бэлтгэгдсэн багш байдаггүй, багш нар үндсэн заадаг хичээлийнхээ хажуугаар зааж байгаад яваандаа бүр тэр хичээлээ орохоо ч больсон. Түүний оронд тэд эрүүл мэндийн боловсролын хичээлийн цагаар дотоод засал чимэглэл, монгол уламжлал, монгол гэр гэх мэт зүйлсийн тухай ярьдаг болсон. Жишээлбэл, эрүүл мэндийн боловсрол хичээлийг үргэлж биологийн аль эсвэл биеийн тамирын багш заадаг.

Игги (транс хөвгүүн, 17 настай):

Би анх ЛГБТ сэдвийн талаар 8, 9 дүгээр ангид байхдаа Эрүүл мэндийн боловсрол хичээл дээр сонссон. Тэр хичээл хүйсийн баримжаа, бэлгийн чиг баримжааны тухай байсан юм. Тухайн үед эрүүл мэндийн боловсрол хичээлийг зааж байсан биологийн багш харьцангуй нээлттэй яриа өрнүүлсэн. Багш хэдийгээр үүнийг буруу гэж хэлээгүй ч нэг тийм дорд үзсэн, өрөвдөнгүй өнгө аясаар ярьж байсан нь надад муухай санагдсан. Багш, “энэ хүмүүс угаасаа л ийм золгүй, өөрчлөгдөхгүй, нэгэнтээ л нийгмийн хог шаар болж яваа хүмүүс болохоор бид сайнаар хандаж байх хэрэгтэй” гэж хэлсэн. Бид багшаас дорд хүмүүс мэт ярьж байгаа нь надад таалагдаагүй. Түүнчлэн ангийнхан маань энэ хичээлийг нухацтай авч үзэлгүй инээдэм наргиа болгоод өнгөрсөнд нь гомдсон. Ерөнхийдөө, 40 минутын хугацаатай энэ хичээл надад таатай сэтгэгдэл үлдээгээгүй. Ер нь л ийм байдаг, бэлгийн боловсролын хичээлийн үеэр хүүхдүүд инээлдээд л өнгөрдөг. Энэ бол миний ЛГБТ асуудлуудын тухай сонссон цорын ганц 40 минутын хичээл байсан. Үүнээс хойш тийм сэдэв мөн бэлгийн боловсролын талаар дахиж ямар нэг хичээлээр, өөр юугаар ч сонсоогүй.

Игги (транс хөвгүүн, 17 настай):

Эрүүл мэндийн боловсролын хичээлд зориулсан сурах бичиг гэж байдаг. Гэхдээ хүүхдүүд тэрийг бараг хэрэглэдэггүй. Сургуулийн номын санч зорилтот бүлгийн хүүхдүүдэд ном сурах бичиг өгдөг. Манай гэрээс нэгэн зэрэг гурван хүүхэд сургуульд сурч буй тул би зорилтот бүлэгт багтаж ном авсан юм. Номуудаа хүлээж авахад дунд нь эрүүл мэндийн

боловсролын хичээлийн сурах бичиг байсан нь цоо шинээрээ, хуруу зүсэм шинэ хуудастай байж билээ. Хүүхдүүд тэр сурах бичгийг нээж үздэг ч үгүй, хэзээ ч уншдаггүй, яагаад гэвэл багш нар эрүүл мэндийн боловсролын хичээлийг заая гэж боддоггүй. Тэдний хувьд энэ сурах бичиг ямар ч хэрэггүй.



Синди

(транс охин, 16 настай):

Багш нар зүгээр л буруу мэдээлэл ил тод тарааж байдаг, үүнийг юу гэж хэлдэг билээ? Күйр сэдвийн талаар ямар ч ойлголтгүй, сурагчдад өөрсдийн буруу үзэл суртлаа тулган заах гэх юм уу. Сурах бичиг дээр байж байхад хүртэл. Намайг 8 дугаар ангид байхад билүү дээ, ЛГБТК-тэй холбоотой сэдэв гарч ирсэн юм. Багш (эрэгтэй) энэ сэдвийн тухай зүгээр л ил цагаан худлаа ярьж эхэлсэн. Гей найзуудтай байх ямар хэцүү болох талаар, тэдэнтэй өөрөөр харьцаж байхгүй бол “буруугаар ойлгочихдог” гэх мэт нэг тийм тэнэг юм хэлсэн. Хэрэв тэдэнтэй энгийн харьцаж, сайнаар хандвал “буруугаар ойлгоно” тэгээд чамтай сээтгэнэх эсвэл чамайг ашиглах гэж оролддог ч гэлүү дээ. ЛГБТИК+ багтаасан хичээл чухал гэдэг нь ойлгомжтой ч багшийн маань зааж байгаа нь үнэхээр муу байсан, аймшигтай.



БАГШ НАРЫН СӨРӨГ ХАНДЛАГА

Тус судалгааны үр дүнд гойд анхаарал татсан нэг зүйл байсан нь багш нарын транс сурагчид руу чиглэсэн сөрөг хандлага, хүчирхийлэгч авир, зан үйл юм. Эрүүл мэндийн боловсролын хичээл сургалтын хөтөлбөрт орж ирсэн хорин жилийн өмнөх үеэс нөхцөл байдал огт дээрдээгүй аж. Транс сурагчдын хариулж байгаагаар сургууль дээр багш нар транс сурагчдын эсрэг ялгаварлан гадуурхах хандлагатайн дээр үе тэнгийн дээрэлхэлтийг таслан зогсоох бүс өөгшүүлэн дэмжих зан үйл тогтжээ. Энэхүү судалгаанд оролцсон транс сурагчдын хувьд тэд эрэгтэй, эмэгтэй хүн хэмээх сизнорматив үзэл санаанд үл нийцэх транс байдал, хүйсийн илэрхийллээсээ болж багш нарынхаа зүгээс ирдэг олон төрлийн хүчирхийлэгч зан үйлийг үзэж түүлж байгаа аж. Тэрхүү хүчирхийлэгч зан үйлд үг хэлээр доромжлох, тодорхой хэмжээнд бие махбодын хүчирхийлэл үзүүлэх, цаашлаад бэлгийн дарамт ч багтана. Транс сурагчид зөвхөн үе тэнгийн дээрэлхэлтэд өртөж буй биш бөгөөд багш нарын үйлдэж буй ялгаварлан гадуурхалт, олон төрлийн хүчирхийлэгч зан үйлийн үршгаар тэд улам ганцаардаж, шахагдан хавчигдаж байна.



Баяр (транс хөвгүүн, 16 настай):

Дарамт мэдэрдэг зүйл маань ихэвчлэн багш нар л байдаг даа. Өнгөрсөн жилээс хойш би нэлээд өөрчлөгдөж, өөрийгөө илүү эршүүд байдлаар илэрхийлж эхэлсэн. Хүүхдүүдийн өмнө багшаар олон удаа доромжлуулсан. Чи чинь эмэгтэй хүүхэд биз дээ? Яагаад эрэгтэй хүүхдийн хувцас өмсөөд, эрэгтэй хүүхэд шиг аяглаад байгаа юм? Эмэгтэй л юм бол бусад эмэгтэйчүүд шиг цэвэрч, тус нэмэртэй байж сур. Байгаа байдал чинь заваан, замбараагүй, огтхон ч эмэгтэй хүн шиг биш байна, гэх мэт. Би маш их гомдож эмзэглэсэн.

Жолие (транс охин, 17 настай):

Алхаж, аяглаж байгаа байдал, нүдний будаг хэрэглэсэн эсэх зэргээр минь багш нар намайг байнга л шүүж, шүүмжилж, загнаж байдаг. Эр хүн шиг бай гэнэ... Биологийн багш маань (эмэгтэй) нэг удаа транс эмэгтэйтэй таарч байсан тухайгаа хичээлийн үеэр ярьсан. Багш

“Гудамжинд маш гоё бүсгүй урд минь алхаж байлаа. Би алхаагаа хурдасгаж, хажуугаар нь зөрөхдөө царайг нь харсан юм. Тэгсэн тэр бүсгүй эрэгтэй хүн байсан, аймшигтай царай муутай. Миний ой гутсан.” Тэгтэл ангийнхан маань миний нэрийг хэлж “Багш аа, та Жolieгийн эгчтэй тааралдсан юм биш үү?” хэмээн инээлдэцгээсэн... Би бас нэг багштайгаа ярилцаж үзсэн. Тэр багш харьцангуй залуу хүн болохоор намайг ойлгох байх гэж найдсан юм. Гэвч хичээл дуусахад багш намайг хүүхдүүдийн дэргэд нэрээр минь дуудаж, маргааш гэхэд ямар хүйстэй гэдгээ мэдэж ирэх даалгавар өгсөн. Би гайхаж хоцрохоос өөр юу ч хийж чадаагүй.

Кас (транс хөвгүүн, 16 настай):

Хичээл дээр заах сэдэвт ЛГБТК олон нийтийн тухай огт дурдаагүй байхад багш нар амьдралын тухай бидэнд сургаал айлдахдаа энэ талаар ярьдаг. Жишээлбэл, манай нийгмийн ухааны хичээлийн багш (эрэгтэй) юмсын талаар өөрийн үзэл бодлыг хуваалцах их дуртай. Тэр багш гомофоби бөгөөд ЛГБТК хүмүүстэй холбоотой асуудлаар ямар нэгэн байдлаар өөрийн үзлийг илэрхийлдэг. Ммм.. өөрийнх нь зааж байгаа хичээлтэй ямар нэг уялдаа холбоогүй байхад ярьж байсан зүйлээсээ хазайж, ЛГБТК сэдэв рүү ороод “одоо үед хүмүүс гурав дахь хүйс байх болсон гэж хачин солиотой юм ярих болсон” гэж хэлж байв. Орос сургууль болохоор багш нар нь шашин шүтлэг ихтэй, үргэлж л Бурханыг дурдаж байдаг юм. Тэд бурхан эрэгтэй, эмэгтэй хүнийг бүтээсэн, тийм ч учраас зөвхөн Адам, Ева гэж л байна гэдэг. Үгүй байсан бол бид хэрхэн нөхөн үржиж, хүн ам хэрхэн өсөх билээ? гэх мэт. Нэг удаа хичээлийн дундуур нийгмийн ухааны багш гэнэтхэн “Та нар Ромео, Жулета хоёрт дуртай биз дээ? Хоёр Ромео байсан бол ой гутмаар байна биз?” гэж биднээс асууж байв.

Хантүшиг (нонбайнари, 16 настай):

Газарзүйн багш (эрэгтэй) нэг удаа, дайны дараа эрчүүдийн тоо эрс буурсан, хүн амын 60-70 хувь нь эмэгтэй болмогц ижил хүйстэнтэйгээ явалдах гэх мэт буруу зүйлс үзэгдэх болсон гэж байв. Хүн амын статистикийн тухай ярьж байхдаа байгаль эх өөрөө хүйсийн тэнцвэрийг хангаж байдаг, тийм учраас эрэгтэй, эмэгтэй хүмүүс амар сайхандаа жаргах заяатай гэж тайлбарласан юм. Түүний санаа нь ЛГБТ хүмүүс тэр тэнцвэрийг нь гажуудуулж байна гэж л хэлж байх шиг байсан.

Багш нар ЛГБТИК+ сэдвээр өөрийн итгэл үнэмшилд үндэслэн буруу ташаа мэдээлэл тараах хандлагатай байдаг ба энэ нь хэвшмэл үзэл хандлага, нийгэмд аль хэдийн бугшсан ялгаварлан гадуурхах явдлыг улам өөгшүүлэн дэмжиж байна. Багш нарын ЛГБТИК+ сэдвийн талаарх үзэл хандлага сурагчид энэхүү хичээлд дур сонирхолтой байх эсэхэд нөлөөлөх нь дамжиггүй. Багш нарын сөрөг хандлага транс сурагчдын хичээлийн оролцоо сул байхад нөлөөтэй гэж үзэж болно. Синди (транс охин, 16 настай)-гийн хэлснээр *“Нийгмийн ухааны багш маань күйр хүмүүсийг ‘нийгмийн шаар’ гэх мэтээр байнга л харааж байдаг. “Нийгмийн шаар” хэмээн тодорхойлохоос гадна гомосексуалууд, гомо, лесби, гэмт хэрэгтнүүд гэх мэтээр нэрлэдэг. Багшийг ийнхүү аяглаж эхлэх хүртэл нийгмийн ухааны хичээл миний дуртай хичээл байсан даа.”* Харин Хантүшиг (нонбайнари, 16 настай), яагаад нийгмийн ухааны болон англи хэлний хичээлүүддээ дуртай гэдгээ ийнхүү тайлбарласан юм. *“Би нийгмийн ухааны хичээлд дуртай, яагаад гэвэл багш (эмэгтэй) маань хүний эрхийн өндөр мэдрэмжтэй, хичээл дээр нь ямар ч төрлийн ялгаварлан гадуурхах, шударга бус хандлага гарахыг зөвшөөрдөггүй. Англи хэлний багш маань бас их гоё, нээлттэй сэтгэлгээтэй. Тиймээс би өөрийн хүйсийн баримжаа, илэрхийллийн талаар анх удаа англи хэлний багшдаа хэлж байв. Миний бодлоор гадаад хэлтэй, олон эх сурвалжаас мэдээлэл олж авах боломжтой хүмүүс илүү нээлттэй, бусдыг ойлгодог юм шиг санагддаг.”*

Түүнчлэн багш нарын сөрөг хандлага транс сурагчдын хувьд сурган хүмүүжүүлэгч, сургуулийн ажилтнуудад итгэх итгэлийг хөсөрдүүлдэг болох нь ажиглагдсан. Судалгаанд оролцсон транс сурагчдын олонх нь багш, нийгмийн ажилтан, сэтгэлзүйч, сургуульд ажилладаг хэн нэгэнд хэзээ ч асуудлаа ярьж, тэднээс ямар нэгэн тусламж хэзээ ч хүсэхгүй хэмээсэн билээ. Сургуулийн зүгээс авч үзсэн цорын ганц дэмжлэгийн тухай Баяр (транс хөвгүүн, 16 настай) *“Сургууль дээр миний хүртэж үзсэн хамгийн том тус бол намайг өмд өмслөө гэж загнахаасаа залхаж тоохгүй орхисон явдал юм даа”* хэмээн ярьсан юм.

Игги (транс хөвгүүн, 16 настай):

... дэмжлэг гэх юм сургууль дээр байхгүй дээ. Тэгээд ч би өөрийнхөө тухай, транс байдлынхаа талаар сургуулийн орчинд ярихаас эмээдэг учраас ямар нэгэн тусламж дэмжлэг эрэлхийлж байгаагүй. Багш эрүүл мэндийн боловсролын хичээлээр ЛГБТК сэдвийн талаар ярих үед надад түүнд итгэж болохгүй гэсэн мэдрэмж төрсөн. Тэрээр сизжендер болон стрэйт хүмүүс эгээ л ЛГБТ хүмүүсээс илүү юм шиг өрөвдөн ярьж байсан. Сургууль дээр би хэнд ч итгэдэггүй, хэрэв сургууль дээр хэн нэгэнтэй яривал тэд тэр даруй эцэг эхэд маань хэлэх болно.

Ганц л сурагч багштай холбоотой эерэг туршлагаа хуваалцсан юм. Багшийн эерэг хандлага Хантүшиг (нонбайнари, 16 настай)-ийг өөдрөг болгоод зогсохгүй, түүнд багш нар болон боловсролын тогтолцоог транс сурагчдад ээлтэй болно гэсэн итгэл төрүүлсэн байв.



Хантүшиг

(нонбайнари, 16 настай):

Ангийн зураг авхуулах үед багш маань (эмэгтэй) миний зургийг охид, хөвгүүдийн аль аль хэсэгт оруулсан байсан. Ёстой хөөрхөн. Ангийн багш маань багш нарын өрөөнд байдаг цорын ганц эмэгтэй багш. Тэнд эрэгтэй багш нар намайг эр, эм гэдгээ ч мэдэхгүй хэмээн ярьж байхад багш тэднээс намайг өмөөрч, уурсаж байгааг нь сонсож байлаа. Өмөөрөхийг нь сонсох үнэхээр сайхан байсан. Багш маань настай хүн, тэр надад ЛГБТК-тэй холбоотой асуудлуудыг зөвхөн залуу хүмүүсийн л ойлгодог зүйл биш, хүсвэл ямар ч насны, хэн ч ойлгох боломжтой гэдгийг мэдрүүлсэн. Ирээдүйд хүмүүс үүнийг ойлгодог болох юм байна гэсэн итгэл төрсөн, тиймээс энэ тухай мэдлэг мэдээллийг хамтдаа түгээцгээе.

ДҮР ЭСГЭЖ
АМЬДАРМААРГҮЙ
БАЙНА



ТАВДУГААР БҮЛЭГ:

Хүчирхийлэл, дарамт

Уламжлалт хэм хэмжээ, хүйсийн хэвшмэл ойлголтод нийцэхгүй байгаагаасаа болж транс сурагчид хүчирхийлэл, заналхийлэл, ялгаварлан гадуурхалтад өртөх өндөр эрсдэлтэй гэдэг нь тодорхой баримттай зүйл юм (Ганбаатар, 2021; Stotzer, 2009). Монголын хувьд сургууль бол транс сурагчдад ээлтэй, аюулгүй орчин биш юм. Өмнөх бүлэгт бид хүйсээр ангилан хуваах соёл манай улсын боловсролын тогтолцооны бүрдэл хэсэг бүрд гүн бат оршиж, тэр нь трансжендер олон нийт хүмүүсийн талаарх буруу ойлголт, хайхрамжгүй, харалган тоомжиргүй байдлыг өөгшүүлж буйг, түүнчлэн транс сурагчдын эсрэг үе тэнгийн дээрэлхэлт, багш нарын сөрөг хандлага нийтлэг байсаар байгаа талаар тодорхой өгүүлсэн билээ.

ҮГ ХЭЛЭЭР ХҮЧИРХИЙЛЭХ

Үг хэлээр үйлдэгдэж буй хүчирхийлэл нь транс сурагчдын хувьд сургуулийн болон сургуулийн бус орчинд хамгийн нийтлэг амсаж буй хүчирхийллийн хэлбэр юм. Судалгаанд оролцсон сурагч бүр транс байдалтай нь холбоотойгоор тэдэн рүү шууд чиглэсэн үг хэлээр доромжилсон үйл явдлын талаар тодорхой жишээ дурдан хэлсэн билээ. Заримд нь эдгээр үйл явдлын тухай эргэн дурсах туйлын хүнд байв.

Шинээ (транс охин, 18 настай):

Багаасаа л эргэн тойрны хүмүүсийн тохуурхан шоолохыг сонсдог байсан. Одоо ч хэвээрээ. Хүмүүс байнга л “Чи эрэгтэй юм уу, эмэгтэй юм уу” гэдэг. Заримдаа зүгээр л гомо10 гэж дахин дахин хашхирдаг. Багш нар хүртэл намайг эр, эм нь мэдэгдэхгүй нэг юм гэж хэлдэг, тиймээс би тэдэнд үнэхээр дургүй. Сэтгэлзүй, сэтгэл санааны хүчирхийлэл хамгийн хэцүү нь. Янз бүрээр шоолох, дооглох, тохуурхах гэх мэт. Эрүүл мэндийн боловсролын хичээлээр ЛГБТ-тэй холбоотой сэдэв заахад надад үнэхээр хэцүү байсан, яагаад гэвэл хүүхдүүд бүгд миний нэрийг дуудан инээлдэцгээж байсан. Бага ангид ороход миний нэр гомо болсон, дунд ангид манин11. Яг үнэндээ би зүгээр л хүүхэд шүү дээ. Транс охин байснаараа би янз бүрийн нэрээр дуудуулахыг хүсэхгүй байна. Зарим ээж, аавууд хүүхдүүддээ надтай битгий тогло гэж хэлж

10 Орос хэлний гомосексуал хэмээх үгийн богиносгосон хэлбэр, гомосексуал гэсэн утгатай. Энэхүү богино хэлбэрээр Монгол гей хүмүүсийг нийтлэг нэрлэдэг бөгөөд дорд үзсэн утгатай.

11 Интерсекс гэсэн утгатай ч жендерийн уламжлалт хэм хэмжээнд үл багтах ЛГБТИК+ хүмүүсийг дорд үзэхэд хэрэглэдэг нэр томъёо болсон.

байхыг ч сонсож байлаа, учир нь би эр, эм нь мэдэгдэхгүй амьтан. Ээж, аавын маань ажлын газрынхан ч гэсэн надаас чи чинь хүү юм уу, охин юм уу гэж асууж байв. Аав маань хүртэл намайг охин шиг аяглахаа боль гэж аймшигтайгаар загнадаг.

Үг хэлээр үйлдэгдэж буй хүчирхийлэл сургуулийн орчин дахь үе тэнгийн дээрэлхэлтийн шүүд үр дагавар юм. Цаашилбал, зөвхөн үе тэнгийнхэн ч биш багш нар, эцэг эхчүүд, насанд хүрэгчид транс хүүхдүүдийг сургуулийн орчинд, гэрт нь болон бусад олон нийтийн газар үг хэлээр хүчирхийлэн доромжилдог байна.

Синди (транс охин, 16 настай):

Би түрүүнд хэлсэн дээ, хүүхдүүд ер нь гомофоби байдаг, ялангуяа яагаад тийм гэдгээ ч мэдэхгүй байгаа залуу үеийнхэн. Ерөнхийдөө тэдэнд ийм хандлага багш, эцэг эх, өвөө эмээгээс нь өвлөгдөн суучихсан байдаг гэсэн үг.

Жолие (транс охин, 17 настай):

Гудамжаар явж байхад үг хэлээр доромжуулах бол нийтлэг зүйл. Нэг удаа, миний тодхон санаж байгаагаар нэг ахимаг насны эгч намайг алхаж явааг хараад “Пизда12, юу гээчийн хачин юм харчихав аа би, чи чинь эр юм уу, эм юм уу?” хэмээн орилж, нулимсан. Саяхан би цэцэрлэгт хүрээлэн ороход тэнд залуухан цэргүүд байсан юм. Тэд над руу хараад нэг нь надаас “Чи яасан эр хүн байхаас залхаад нүүрээ будаж, хүүхэн болохоор шийдээ юу?” гэж асуухад бүгд инээлдэцгээсэн.

Игги (транс хөвгүүн, 17 настай):

Өмд өмслөө гэж багш нараар загнуулах үнэхээр зовлонтой. Нэг удаагийн явдлыг би ер мартдаггүй, өмд өмслөө гэж багш маань намайг манин гэж дуудсан. Би үнэхээр их гомдсон.

БИЕ МАХБОДЫН ХҮЧИРХИЙЛЭЛ

Өөрийн жендерээ хэрхэн илэрхийлж буйгаасаа үүдэн бие махбодын хүчирхийлэл амсаж байсан хэмээн зарим оролцогчид мэдэгдсэн бөгөөд ийм хүчирхийлэл түгээмэл амсдаг газар бол сургууль, олон нийтийн газрууд аж. Нэг оролцогч (Хантүшиг, нонбайнари, 16 настай) “охид”-ын хэмээх эмэгтэйчүүдийн үзлэгийн талаар өөрсдийн амсаж туулсан зүйлийн тухай бидэнтэй хуваалцсан юм. “Онгон эсэхийг шалгах үзлэг”

12 Монголд хамгийн түгээмэл хэрэглэгддэг хараалын үг, социалист дэглэмийн үед Орос хэлнээс орж ирсэн эм бэлэг эрхтэн, ал гэсэн үгтэй.

хэмээгддэг энэхүү сургуулийн үйл ажиллагааг дотоодын хүний эрхийн байгууллагууд хүний эрхийн ноцтой зөрчилд тооцдог билээ (Хөөрхөн Зүрхнүүд, 2019).

Хантүшиг (нонбайнари, 16 настай):

Охидын үзлэг ёстой аймшигтай. Хар дарсан зүүд гэж хэлэх байна. Охидын триког тайлуулж, юбкай нь үзлэгийн өрөө рүү оруулсан. Биднийг өрөөнд ороход тэнд хоёр хөшиг л байсан, тэнд хоёр эмч үзлэг хийж байв. Эмч нарын нэр, ямар ч мэдээлэл байхгүй. Болж өнгөрсөн бүх үйл явц надад аймшигтай санагдсан. Юбка өмсөөд үзлэгийн өрөө рүү орохоор бусад сурагчид, багш нарын дэргэдүүр өнгөрөх надад үнэхээр ичгэвтэр байсан. Би ингэхийг үнэхээр хүсээгүй ч багш биднийг тэгэхийг шаардаж жагсааж зогсоож байгаад нэг нэгээр нь явуулж эхэлсэн. Үзлэгийн өмнө эцэг эхчүүдэд маань энэ тухай мэдэгдээгүй. Нэгэнт албадмал, зайлшгүй зүйл болохоор бид бүгд тэр өрөө рүү орж үзлэг хийлгэсэн.

Жолие (транс охин, 17 настай):

Гэрийнхэн маань надад лам, бөө гэх мэт хүмүүсээр шашны холбогдолтой янз бүрийн засал их хийлгэсэн. Тэрхүү засалд нь будаа цацах, сүүгээр нүүр рүү нулимах, номоор цохих, ташуураар ороолгох гэх мэт үйл багтаж байв. Тэд миний биед шингэсэн чөтгөрийн сүнс ч юм уу, ямар нэг юмыг зайлуулж, намайг засаж залруулан жинхэнэ Монгол эр хүн болгохыг хүсэж байна гэж хэлдэг. Транс байхыг засчхаж болдог сон бол би нүүр рүүгээ баяртайгаар будаа цацуулж, намайг ариусгах гэсэн сүүнд нь дэвтэж хэвтсэн ч яах вэ.

Синди (транс охин, 16 настай):

Миний санахаар ихэвчлэн... хоёр гурван удаа бие махбодын хүчирхийлэл амсаж, тэгээд ихэвчлэн үг хэлээр доромжлуулж байсан. Гэдэс, их биеийн хэсэг, гар руугаа ихэвчлэн цохиулна. Голдуу ангид завсарлагаагаар. Тэд юм хэлдэггүй, зүгээр л... Хоёр жилийн өмнө болж байсан болохоор би сайн санахгүй байна, ямар нэг хараал хэлж хашхирч байсан санагдана.

Шинээ (транс охин, 18 настай):

Дунд анги яг там шиг байсан. Бие махбодын хүчирхийлэл илүү түгээмэл, ямар ч шалтгаангүй цохих гэх мэт. Зүгээр сууж байхад эсвэл ангиас гарч ороход цохих, өшиглөх, түлхэх, базах гэх мэт зүйлс олон тохиолдож байсан. Шатаар уруудаж байхад толгой дээр минь шүлсээ хаях явдал ч болж байв. Амьдралынхаа алхам тутамд л дээрэлхүүлж

доромжлуулж ирсэн. Хаа хамаагүй нэг охиноор шоолуулалгүйгээр өөрийгөө толинд харах ч боломжгүй.

Цахим орчин дахь хүчирхийллийн талаар зарим оролцогчид дурдаж байв. Дээрэнгүй сурагчид сошиал медиа ашиглан транс сурагчдыг үзэн ядах групп үүсгэсэн тохиолдол бий аж. Өсвөр үеийнхний дундах цахим хүчирхийлэл, цахим дээрэлхэлтэд анхаарал хандуулах шаардлагатай бөгөөд бай болж буй хүүхэд залуусын хувьд энэ нь туйлын хор уршигтай нь харагдаж байна.

Жолие (транс охин, 17 настай):

Сургуулийн гомофобиуд гэдэг нэртэй Фэйсбүүк групп байдаг. Зургийг маань тэнд оруулж байсан. Бас миний сургуулийн сэтгэлзүйчийн өрөөнд өлгөж байсан солонгон далбааг тэд шатааж буй бичлэгээ оруулсан байсан... “Гомо ал, үхээч. Муу янхан” гэсэн чат мессеж аваад маш их гомдож эмзэглэсэн. Мессеж ирэхээр нээж харахаас ч айдаг, хүмүүс дахиад л намайг янз бүрээр нэрлэж, айлган сүрдүүлж байвал яах вэ гэж боддог.

БЭЛГИЙН ДАРАМТ

Транс хүмүүсийн талаар нийгэмд тогтсон хэвшмэл ойлголт хандлага нь транс байдал, бэлгийн зан үйл хоёрыг хамаатуулан холбож ойлгох явдал байдаг. Транс сурагчид, ялангуяа транс охид “янхан” хэмээн дуудуулж, үг хэлээр хүчирхийлүүлж байснаа дурдаж байв. Нэг сурагч (Жолие, транс охин, 17 настай) ангийнхан нь түүнийг бэлгийн хувьд тохуурхан шоглосон тухай өөрийн түүхээс хуваалцахдаа ...бие махбодын хүчирхийллийг олон удаа амсаж байсан. Хамгийн ой гутмаар байсан нь нэг удаа би санаандгүй нэг юм унагатал тэд намайг доош түлхээд хөвгүүд өмдний тэлээгээ миний өмнө тайлж шоолон инээлдсэн хэмээн ярьсан юм.

Багшийн үйлдсэн өөр нэгэн хүчирхийлэл болох бэлгийн дарамтыг Баяр (транс хөвгүүн, 16 настай)-ын хариултаас анзаарч болно. Багш нар, ялангуяа эрэгтэй багш нар хөвгүүдийг цохиж, үүнийгээ жинхэнэ эр хүн хэдэн цохилт даах чадалтай байх ёстой гэсэн эр хүн хэмээх уламжлалт ойлголтоор зөвтгөдөг байна. Тэр багш транс хөвгүүний цээжинд хүрч “эр улс нэгнийхээ биед хүрч болдог, чи үнэхээр эр хүн юм бол зөвшөөрөх л болно доо” хэмээжээ.

Өнгөрсөн жил намайг өмд өмсөж эхлэх үед ангийн багш (эрэгтэй) ганцааранг минь дуудаж уулзсан. Багш надаас өөрийгөө хэрхэн тодорхойлж байгааг асуусан. Яагаад өмд өмсөж байгаагаа түүнд тайлбарлавал өмд өмсөхийг минь зөвшөөрнө гэсэн. Би түүнд тайлбарлатал багш “Тэгэхээр чи эрэгтэй юм биз дээ, ай?” гэж хэлэхэд байдал нэг л сонин болчихсон. Надад ямар нэг төрлийн бэлгийн дарамт шиг санагдсан. Тэгээд багш “Хэрэв чи үнэхээр эр хүн юм бол би чамд хүрч болно биз дээ?” гэж хэлээд надаас хөхтэй юу гэж асуусан. Надад тавгүй байхад тэр асуусаар л байсан. “Чи өөрийгөө сая эрэгтэй хүн гэж хэлээгүй билүү?” Багш 35-40 орчим насны хүн, тэгээд миний цээжинд хүрсэн. Намайг туйлын тавгүй байгааг тэр хараад “эрчүүд бид гүндүүгүй¹³ улс гэдгийг мэднэ биз дээ, гэтэл чи өөрийгөө хар даа, яг л охин шиг байгаа биз?” гэж хэлсэн. Миний цээжинд гарын алгаараа хүрсэн. Эхэндээ намайг ойлгохыг хичээж байгаа юм шиг байснаа цээж, биед маань хүрсэн. Энэ байдал үргэлжилсэн бол би хэн нэгэнд энэ тухай хэлэхгүй л байх байсан болов уу. Хэрэв би хүнд хэлбэл багш “Чи чинь эр хүн гээгүй билүү?” гэх болно, тэгээд би түүнд хүлээн зөвшөөрөгдөхөө болино гэсэн үг.

13 Гүндүүгүй гэдэг нь өв тэгш Монгол эр хүний талаарх хэвшмэл ойлголт бөгөөд цайлган, дүүгүй, тайван, тэвчээртэй байдлыг илэрхийлдэг.





ЗУРГААДУГААР БҮЛЭГ:

Сэтгэцийн эрүүл мэнд

Транс болон хүйсийн олон янз байдал бүхий хүмүүс хүн амын бусад хэсэгтэй харьцуулахад сэтгэцийн эрүүл мэндийн хувьд доройтох нь элбэг (Russon et al, 2022; Lenning & Buist, 2013) бөгөөд транс болон транс биш хүмүүсийн эрүүл мэнд, ялангуяа сэтгэцийн эрүүл мэндийн хооронд үүсэж буй тэгш бус байдал улам тэлж байна (Miranda- Mendizábal et al, 2017). Хэдийгээр транс хүмүүсийн дунд сэтгэл гутралын хувь өндөр боловч сэтгэцийн эрүүл мэндийн тусламж авахаас зайлсхийх хандлага мөн өндөр байдаг аж (McNeil et al, 2012).

ХҮЧИРХИЙЛЭЛ, ЯЛГАВАРЛАН ГАДУУРХАЛТЫН НӨЛӨӨ

Энэхүү кэйс цуглуулгын судалгааны туршид хүчирхийлэл, сэтгэцийн эрүүл мэнд хоёрын хооронд нягт холбоо байгаа нь ажиглагдаж байв. Бие махбод, үг хэлээр үйлдэгддэг хүчирхийлэл, бэлгийн дарамтад өртөж байсан транс сурагчид өөрт нь тохиолддог эдгээр ялгаварлан гадуурхалт, заналхийллээс үүдэн амиа егүүтгэх бодол тээх, оролдох, өөрийгөө гэмтээх өндөр эрсдэлд байгаа гэдгийг энд цохон тэмдэглэх хэрэгтэй. Цаашилбал, зарим транс сурагчид хүчирхийллээс зайлсхийх зорилгоор өөрийн транс гэдгийг нууж, жендерийн хэвшмэл дүрд нийцэх гэж хичээдэг байна.

Сургууль дээр хүүхдүүд гомофоби гэх зүйл тэдний дотор гүн шигдсэн байгааг мэддэггүй. Тэд биднийг хэвийн гэж хардаггүй бөгөөд энэ үзэл хандлагаа өөрчлөх бүрэн боломжтой ч тэгэхийг хүсдэггүй. Яагаад гэвэл сургууль дээр үүнтэй холбоотой зөв мэдээлэл огтхон ч байдаггүй. Би өөрийн транс гэдгийг сайн нууж чаддаг гэж бодож байна. Бүгд намайг сизжендер, стрэйт гэж боддог. Монголд өөрийгөө нуух эсвэл транс гэдэг нь мэдэгдэхгүй¹⁴ буюу илэрхийлж буй хүйсэндээ бүрэн харагдах нь маш чухал. Хүчирхийлэл, заналхийлэл тохиолдох боломж маш их. Эр, эм нь мэдэгдэхгүй¹⁵ гэдэг үг, иймэрхүү хэлц байгаа нь транс гэдэг нь илт мэдэгддэг хүмүүсийн хувьд бие махбодын хувьд үнэхээр аюултай санагддаг.

14 Транс гэдэг нь мэдэгдэхгүй гэдэг нь транс хүн жендер, хүйсийн хувьд өөрийн илэрхийлж буй хүйсээрээ бусдын нүдэнд харагдахыг хэлдэг. Өөрөөр хэлбэл транс хүн бусдад сизжендер хүн мэт ойлгогдохыг хэлнэ.

15 Эр эм нь мэдэгдэхгүй гэдэг нь жендерийн уламжлалт хэм хэмжээнээс гадуур хүмүүсийг доромжлоход нийтлэг хэрэглэгддэг хэлц.

Сургуулийн орчны ялгаварлан гадуурхалтын өөр нэгэн шууд үр дагавар нь үл оролцуулах байдал. Транс сурагчдыг хүйсийн баримжаанаас нь шалтгаалан сургуулийн үйл ажиллагаа, багаар ажиллах даалгавар зэрэгт үл оролцуулдгийг зарим оролцогчид дурдаж байв. Үл оролцуулах нь тухайн сурагчид ганцаардах, өөртөө итгэх итгэл нь буурах, суралцах үйл ажиллагаанд оролцох хүсэлгүй болох зэрэг сэтгэлзүйн олон сөрөг үр дагаврыг авчирдаг.

Шинээ (транс охин, 18 настай):

Сургууль дээр надад намайг дэмждэг найз нөхдийн хүрээлэл байхгүй. Бүгд ширээнд хоёр хоёроороо суудаг байхад би ганцаараа суудаг.

Жолие (транс охин, 17 настай):

Анги дээр багаар ажиллах болоход би ганцаар үлддэг, яагаад гэвэл намайг хэн ч багтаа авахыг хүсдэггүй. Зарим хичээл дээр би багаараа гүйцэтгэж байгаа даалгаврыг ганцаараа хийх хэрэгтэй болдог яагаад гэвэл өнөө л намайг багтаа авахыг хүсдэггүй гэх шалтгаан. Ингэлээ гээд би тэдэнтэй маргалдвал тэд “чамд эрх байдаг юм бол бидэнд ч бас өөрийн үзэл бодлыг чөлөөтэй илэрхийлэх эрх бий, бид чамайг үзэн ядах эрхтэй” хэмээн амыг минь тагладаг.

СЭТГЭЦИЙН ЭРҮҮЛ МЭНДЭД ҮЗҮҮЛЭХ ҮР ДАГАВАР

Тус судалгаанд оролцсон транс сурагчид ахлах сургуулийн үүр амьсгалыг туйлын дарамттай хэмээн тодорхойлсон юм. Дарамт хэмээх нэр томъёо нь дээрэлхэлт, үл оролцуулах байдал, цөөнх байх зэрэг нөхцөл байдлаас үүдсэн сэтгэц, сэтгэлзүйн ачаалалтай холбоотой утгаар энд хэрэглэгдэж буй юм. Үүн дээр нэмээд хүйсийн үл нийцэл нь тэдэнд нэмэлт дарамт, өөрийн биедээ тавгүйтэх зэрэг мэдрэмжийг төрүүлж өөртөө итгэх итгэлийг нь бууруулдаг байна. Эдгээр сэтгэцийн эрүүл мэндийн асуудалтай холбоотой гурван үндсэн үр дагавар ажиглагдсан нь а) тусгаарлах, б) муу зуршил/өөрийгөө гэмтээх, в) амиа егүүтгэх сэдэл, оролдлого зэрэг юм.

ӨӨРИЙГӨӨ ТУСГААРЛАХ

Сэтгэцийн эрүүл мэндийн үр дагавартай холбоотой тус судалгаанд оролцсон транс сурагчдад хамгийн нийтлэг ажиглагдсан хэв шинж нь өөрийгөө тусгаарлах явдал байв. Бараг л бүх оролцогчид ямар асуудалтай тулгарч байгаагаа хэнд ч хэлэхгүй өөрийгөө тусгаарлан ганцаар байдаг хэмээн хариулсан билээ. Тэд шударга бусаар шүүгдэх, хүчирхийлүүлэх айдсаас болж мөн сургууль дээрх мэргэжлийн ажилтан, багш нарт итгэх итгэлгүй зэрэг шалтгаанаас үүдэн хэнд ч юу ч хэлэхгүй байх, ямар нэг тусламж дэмжлэг эрэлхийлэхгүй байхыг илүүд үздэг байна. Үүний оронд тэд сэтгэл хөдлөлөө дотроо дардаг аж. “Юу ч болж байсан би хэнд ч ханддаггүй, бүх зүйлийг ганцаараа л даван туулах ёстой, өөр арга зам байхгүй” хэмээн Жолие (транс охин,

17 настай) хариулсан юм. Зарим транс сурагчид бусад күйр найзуудтайгаа холбоо тогтоодог гэсэн боловч өөрийгөө тусгаарлаж ганцаар байх аргагүй болсон үед л ингэдэг аж.

Игги (транс хөвгүүн, 17 настай):

Ямар нэгэн зүйл тохиолдох үед би найзууддаа хамгийн түрүүнд хэлмээр санагддаг, гэхдээ тэгдэггүй. Асуудал гарахад би эцэг эхдээ, багш нарт, сургууль дээр байгаа ер нь хэнд ч энэ тухай ярьдаггүй. Ихэвчлэн дуугаа хурааж мэдрэмжээ илэрхийлэлгүй, хэнд ч бодлоо хуваалцалгүй суудаг.

Баяр (транс хөвгүүн, 16 настай):

Анхандаа би асуудал тулгарах үед чадлынхаа хэрээр нуудаг байсан. Ингээд нэмэргүй бол найзууддаа хэлж магадгүй. Яг үнэнийг хэлэхэд би өөрт тохиолддог асуудлуудынхаа тухай, жишээлбэл ариун цэврийн өрөөний тухай хэнд ч хэлж байгаагүй. Хүмүүс намайг доромжилбол би найзууддаа хэлж магадгүй. Ямар нэг тусламж, мэдээлэл хэрэгтэй болсон үед хамгийн түрүүнд ханддаг зүйл маань Интернэт.

Цаашлаад, интернэт нь тусламж, тайвшрал олох, тойрон хүрээлэлтэй болох талбар болдог гэдгийг оролцогчид хэлж байв. Ихэнх транс сурагчид сургууль дээрээ эсвэл гэртээ хэн нэгэнтэй ярилцахын оронд цахим орчинд ордог байна.

Синди (транс охин, 16 настай):

Ямар нэг хүнд хэцүү зүйл тохиолдоход би ихэвчлэн ганцаараа л байдаг. Өөр нэг их юм хийж чаддаггүй дээ. Тэгээд найзууддаа хандана. Би хэн болохоо күйр найзууддаа хэлсэн. Найзуудын хувьд надад гомофоби болон күйр гэсэн хоёр бүлэг найзууд бий. Нийгмийн хоёр өөр хүрээлэл. Надад гурван хүнтэй групп чат бий. Энд ангийн маань нэг, хуучин ангийн маань бас нэг хүүхэд байдаг. Би тэнд чалчиж өгдөг. Заримдаа тэд хариу бичдэг, заримдаа бичихгүй. Тэнд бичих нь гоё санагддаг.

МУУ ЗУРШИЛ / ӨӨРИЙГӨӨ ГЭМТЭЭХ

Бидэнд мэдэгдсэн өөр нэгэн үр дагавар нь транс сурагчид бага наснаасаа эхлэн согтууруулах ундаа хэрэглэж, тамхи татдаг болсон бүрүү зуршил байв. Илүү анхаарал татсан зан үйл нь өөрийгөө гэмтээх. Транс сурагчдын хувьд өөрийгөө тусгаарлан ганцаараа байх нь дасан зохицох анхны сөрөг механизм байж болох ба энэ нь цааш өөрийгөө гэмтээх гэх мэт өөр олон зан үйлд хөтөлдөг байна. Тусламж дэмжлэг

хомс байдал, сурган хүмүүжүүлэгчидтэй холбоотой сөрөг таагүй үйл явдлууд энэхүү хортой зан үйл төлөвшихөд түлхэц болж буй хэмээн таамаглаж байна.

Синди (транс охин, 16 настай):

Надад компьютер тоглохоос өөр хобби гэх зүйл байхгүй болохоор энийгээ л тоглосоор байдаг. Гааз үнэрлэдэг нэг тийм давалгаа өрнөсөн. Гэхдээ миний сонирхох зүйл биш гэж би бодсон. Заримдаа өөрийгөө гэмтээдэг. Цаасны хутгаар хөлөө зүсдэг байсан. Тиймэрхүү гэмтэл сар орчим болж байж эдгэдэг. Хагас жилийн өмнөөс би энэ зуршлаа больсон.

Шинээ (транс охин, 18 настай).

Юу ч бодолгүй ганцаараа байх дуртай. Асуудал тулгарсан үед хэн ч намайг харахгүй, хэн ч миний тухай ярихгүй тийм орчинд ганцаараа байх юмсан гэж боддог. Заримдаа их хэмжээгээр чихэрлэг юм идэж эхлэх, эсвэл ухаангүй болтлоо ууж бүхнийг мартаж нь амар санагддаг. Миний насан дээр согтууруулах ундаа ууж болохгүй л дээ, гэхдээ би 13 настайгаасаа хойш бага багаар уусан. Надад насанд хүрсэн найзууд бий, тиймээс уух нь асуудлаа мартаж нэг арга болдог.

АМИА ЕГҮҮТГЭХ СЭДЭЛ, ОРОЛДЛОГО

Хүчирхийлэл, нэмээд сургууль, гэр бүл, нийгмийн зүгээс ямар нэгэн дэмжлэг байхгүй зэрэг шалтгаанаас улбаалан транс оролцогчдын дунд амиа егүүтгэх сэдэл нийтлэг байгаа нь ажиглагдсан. Транс сурагчдын хувьд транс биш үе тэнгийнхнээсээ илүүтэйгээр амиа егүүтгэх сэдэлд өртөмтгий байгааг хэдэн хүчин зүйлээр тайлбарлах боломжтой юм. Амиа егүүтгэх сэдэл нь дотоод (хүйсийн нийцэмжгүй байдал, транс байдлаа үзэн ядах хандлага) болон гадаад (үе тэнгийн дээрэлхэлт, хүчирхийлэл, ялгаварлан гадуурхалт) гэсэн цөөнхийн сэтгэлзүйн дарамттай холбоотой байдаг (Grossman болон бусад судлаачид, 2016). Энэхүү судалгаагаар дотоод дарамт буюу хүйсийн нийцэмжгүй байдал, транс байдлаа үзэн ядах хандлагын талаар судлахаас илүүтэйгээр гадаад дарамтын талаар илүү судалсан болно. Хүйсээр ангилан хуваах, багш нарын сөрөг хандлага, үе тэнгийн дээрэлхэлт, хүчирхийлэл, заналхийлэл зэрэг гадаад дарамт Монголын транс сурагчдад амиа егүүтгэх сэдэл төрүүлэх гол хүчин зүйлс болж байна.

Баяр (транс хөвгүүн, 16 настай):

Би их гунигтай хүүхэд байсан. Хүүхдүүд өсвөр насандаа голдуу амиа хорлох тухай боддог. Харин би бүр бага ангид байхдаа л үхмээр санагддаг байв. Өөрийнхөө ийм гэдгийг мэддэг, тэгээд хүйсээ өөрчилмөөр байвч хүмүүс намайг үзэн ядахаас айдаг байсан. Үзэн ядуулж, ганцаар хаягдахыг хүсэхгүй байсан болохоор амиа хорлочихсон нь дээр юм байна гэж боддог байсан. Би дэлхий дээр ганцаараа л ийм юм байна гэж бодож олон жил шаналсан даа.

Өөр бусад ЛГБТИК+ хүмүүс оршин байдаг талаар интернэтээр дамжуулан олж мэдсэн нь амиа егүүтгэх тухай бодлыг нь өөрчилсөн хэмээн Баяр (транс хөвгүүн, 16 настай) үргэлжлүүлэн ярьсан юм. “Багш тэр слайд танилцуулга дээр бэлтгэсэн эрүүл мэндийн боловсролын хичээлийг илгээхэд би надтай адилхан өөр хүмүүс байдаг гэдгийг мэдсэн. ЛГБТ Төвийн цахим хуудсыг олсноор би ганцаараа ийм хачин биш юм байна, бид чинь олуулаа юм байна гэж бодсон. Үнэнийг хэлэхэд тэр мэдээллийг уншиж мэдэхээс өмнө би үргэлж амиа хорлох тухай бодож явдаг байсан. Мэдээлэл авснаар өөрийгөө илүү ойлгож, бусдад өөрийгөө нээхэд тустай байсан.”



Жолие

(транс охин, 17 настай):

Туйлын хүнд нөхцөл орж байсан учраас би хэд хэдэн удаа амиа хорлох оролдлого хийж байсан. Намайг байхгүй болчихвол бүх юм сайхан болох юм шиг би бодсон. Заримдаа аяга таваг угаагаад зогсож байхдаа тэнд байгаа хутгыг хараад түүгээр амиа амархан егүүтгэх юм шиг санагддаг ч өвдөхөөс нь айгаад больдог. Нэг удаа би хутга сугалж хүзүүндээ аваачин өөрийгөө егүүтгэх гэсэн ч хутга ир муутай байсан тул зүсэгдээгүй өнгөрсөн. Ууртай үедээ л ингэчихдэг. Тайвширсан хойно энэ тухай бодох хэцүү болдог.



ДОЛДУГААР БҮЛЭГ:

Сургуулиас гадуурх амьдрал

ГЭР БҮЛ

Эцэг эх, гэр бүлийн дэмжлэг транс хүүхдүүдийн хувьд амин чухал юм (Linder, 2014). Гэр бүлдээ үл хүлээн зөвшөөрөгдсөн өсвөр залуу насныхан амиа егүүтгэх, сэтгэцийн эрүүл мэндийн доройтолд өртөх магадлал илүү өндөр байдаг (Grossman et al, 2005). Гэр бүлийн гишүүдтэй холбоотой таагүй үйл явдлууд Монголын ЛГБТИК+ залуусын амьдралыг үзэх үзэл хандлагад гүнзгий нөлөө үзүүлдэг хэмээн өмнөх судалгаанд дурджээ (Ganbaatar et al, 2021). Энэхүү судалгаанд оролцсон транс сурагчдын дийлэнх нь гэр бүлийн зүгээс ямар нэгэн дэмжлэг мэдэрдэггүй учраас өөрийн хүйсийн баримжааны талаар тэдэнд мэдэгдээгүй хэмээн хариулсан юм. Зарим оролцогчдын гэр бүлийн гишүүд үг хэлээр хүчирхийлэн доромжилж байсан тухай ч мөн дурдсан билээ.

Баяр (транс хөвгүүн, 16 настай):

Хоёр жилийн өмнө ээж маань утсаа харж байгаад Хятадад Ши Жинпин ЛГБТ хүмүүсийг телевизээр гарахыг хориглосон тухай уншихад аав түүнийг нь зөвтгөж, тэд хамтдаа ЛГБТ хүмүүсийг доромжилсон. Тэр үед би тэднийг хэзээ ч намайг ойлгохгүй юм байна гэж бодсон.

Жолие (транс охин, 17 настай):

Эцэг эх маань салчихсан. Тэдний хэнд ч би хэлж зүрхлэхгүй. Аав маань жинхэнэ монгол эр хүн нэг тийм байх ёстой гэсэн итгэл үнэмшилтэй. Хэрэв тэр мэдвэл би хэдий төрсөн хүүхэд нь ч гэлээ намайг алах байх. Ээж харьцангуй дөлгөөн, гэхдээ намайг угаасаа ойлгохгүй. Аавтай уулзах болгонд намайг эр хүн шиг байж чадсангүй, охин шиг ярилаа гэж загнадаг. Заримдаа би жинхэнэ гэр бүлтэй байсан бол гэж боддог. Миний шинэ жилийн баярын хүсэл жинхэнэ гэр бүлтэй болох. Мэдээж хэрэг Санта өөрөө ч жинхэнэ биш л дээ (инээв).

Синди (транс охин, 16 натай):

Үгүй ээ, би гэр бүлийнхэндээ өөрийнхөө тухай хэлээгүй. Яав ч хэлэхгүй. Манай аав ил цагаан фашист. Төрийн өндөр албан тушаал хашиж байгаа хүмүүсийг хятад, хятадаас дүрвэж Монголд ирсэн гэх мэт зүйлс үглэж байдаг. Аав дайныг ч мөн дэмждэг байх. Би аавын ажлын үйлдвэрт хоёр сар ажилласан. Миний үеийнхэнд хэрхэн урам нь хугарч явдаг тухай гомдоллоно. Аавтайгаа дотно биш болохоор үүнд нь би нэг их эмзэглэдэггүй. Харин ээж ямар нэг гомофоби, күйрфоби зүйл хэлэхэд намайг хатгаад авах шиг болдог. Надад нэг ах бий ч тэр маань 20 насаар ах болохоор бид хоёр бараг хоорондоо ярьдаггүй. Тэр өөрийнхөө юмыг хийгээд явж л байдаг. Күйр хүмүүсийн талаарх гэрийнхний маань хандлага үнэхээр муу, үнэхээр муухай. ДОХ-ын тухай гей хүмүүсийн өвчин, сармагчны тэмбүү гэх мэт буруу мэдээлэлтэй. Байгалийн жам ёсных гэж боддоггүй, сэтгэцийн өвчтэй, бурхнаас заяасан бие махбодоо сүйтгэж байна гэж үздэг.

Азаар зарим төрлийн гэр бүлийн дэмжлэг байдаг талаар оролцогчид маань дурдсан юм. Оролцогч транс сурагчдын маань хувьд гэр бүлийн дэмжлэг тэднийг хамгаалах хүчин зүйл мөн болох нь тодорхой байв. Гэр бүлийн дэмжлэг мэдэрдэг сурагчид амиа егүүтгэх болон өөрийгөө гэмтээх зан үйлийн талаар бага дурдаж байсан юм. Харин үүний оронд тэд илүү эерэг байж илүү гэрэлтэй ирээдүйг зорьж байгаа нь ажиглагдаж байлаа.

Хантүшиг (нонбайнари, 16 настай):

Voice шоу үзэж байгаад эцэг эх маань Lana-гийн тухай асуусан. Тэд “ямар эршүүд хоолойтой охин бэ” гэхэд нь би тэдэнд түүнийг ЛГБТ хүн гэдгийг нь тайлбарлаж хэлсэн. Тэгэхэд тэд гайгүй л байх шиг байсан. Бас ээжийн маань дунд сургуулийн хамгийн сайн найз нь гей, гадаадад амьдардаг юм. Тийм болохоор би ээжид их найдаж байгаа. Бас ээж маань өөрөө миний үсийг засаж өгдөг болсон. Анхандаа намайг үсээ богино болгоход их гайхаж байсан ч, одоо зүгээр.

Ирээдүйн амьдралынхаа тухай Хантүшиг (нонбайнари, 16 настай) би нэг охинтой гэрлээд хоёр хүүхэдтэй болохыг хүсдэг. Ээж маань надаас хэдэн хүүхэдтэй болохыг хүсэж байна гэж асуухад нь би хоёр гэж хэлэхэд их баярлаж байсан. Ээж намайг стрэйт л гэж бодсон байх хэмээн ярьсан юм.

Кас (транс хөвгүүн, 16 настай):

Би транс гэдгээ эцэг эхдээ хэлээгүй. Ээждээ харин бисексуал гэдгээ хэлсэн. Ээж аавд хэлсэн, хэн хэн нь намайг дэмждэг гэж бодож байна. Бисексуал байдлын маань тухайд бол ээж маань аз жаргалтай л



#ЯЛГАВАРЛАН
ГАДУУРХАЛТЫГ
ЗОГСООЁ

байвал чи хэнтэй ч байсан яах вэ гэсэн хандлагатай... Юутай ч тэд аль алин нь мэдсэн ч надтай харилцах хандлага нь өөрчлөгдөөгүй. Аавыг би сайн мэдэхгүй юм, гэхдээ ээж их гомофоби байсан. Тэгээд миний бисексуал гэдгийг мэдээд үүнийг хүлээн зөвшөөрч эхэлсэн.

АКТИВИЗМ

Транс сурагчдаас бид ЛГБТИК+ олон нийт тэдний амьдралд ямар ач холбогдолтой талаар, мөн ЛГБТИК+ эрхийн активизмын эерэг нөлөөг мэдэж авсан билээ. Дотоодын ЛГБТИК+ эрхийн хөдөлгөөн нь өөрсдийн нийгэмд харагдах байдлыг нэмэгдүүлэх замаар Монгол дахь транс залуу үеийн сэтгэцийн эрүүл мэнд болон тэдний эрүүл энх, сайн сайхан аж төрөхүйд хувь нэмэр болдог байна (Ганбаатар ба бусад, 2021). Олон нийтээр дамжуулан ямар нэг зүйлд харьяалагдах мэдрэмжийг мэдрэх нь оролцогчдын маань хувьд өөрийгөө хүлээн зөвшөөрөх, өөрөөрөө бахархах, ганцаараа биш гэдгээ мэдрэх гэх мэт итгэл найдварын эерэг сэтгэл хөдлөлийг төрүүлдэг аж. Эерэг сэтгэл хөдлөл нь сэтгэцийн эрүүл мэндээс гадна бие махбод, сэтгэлзүй, нийгмийн сайн сайханд тус нэмэртэй юм (Fredrickson et al, 2008).

Дотоодын ЛГБТИК+ хөдөлгөөн тэдний хувьд ямар чухал байсныг, түүнчлэн ЛГБТИК+ хүмүүс нийгэмд ил харагдах нь хэрхэн тэдний хайр, өөртөө итгэх итгэл, даван туулах чадварыг тэтгэж өгснийг Хантүшиг (нонбайнари, 16 настай) ийнхүү ярьсан юм.

Бидний хувьд дотоодын ЛГБТИК+ хөдөлгөөн болох ЛГБТ Төв нь маш олон төрлийн ач холбогдолтой. Би бараг бүх мэдээллээ Монголын Күйр Подкастаас авдаг. Күйр хосуудын түүхийг сонсох нь зүрхийг минь зүгээр л хайлуулдаг. Эцэг эхийнхээ дэргэд би чихэвч зүүчихдэг болохоор тэд юу ч анзаардаггүй. Гэвч дотроо бол би маш их баяр хөөр, аз жаргалыг мэдэрч байдаг. Подкастын дугааруудаас сонссон зүйлс минь дараа хэн нэгэн намайг муулах, доромжлох үед өөрийгөө хамгаалахад хэрэг болдог. Хүмүүс өөрсдийн туршлагаа л ярьж байх шиг байдаг, тэдний ярьж байгаа нь өөртөө итгэх итгэлийг олоход их тус болдог. Тэнд дурдагдсан гол санаануудыг дараа өөрийгөө тодорхой илэрхийлэхэд хэргэлдэг. Бас бусад бахархалтайгаар нээлттэй амьдардаг ЛГБТ хүмүүстэй танилцах, бардам, ил гарсан хүмүүсийг харах боломж олгодог.

Дотоодын хүний эрхийн хөдөлгөөний үр дүнд ЛГБТ хүмүүсийн нийгэмд харагдах байдал ил тод болсон нь олон нийтийнхээ нэг хэсэг хэмээх мэдрэмжийг нь илүү хүчтэй болгож өгсөн хэмээн Хантүшиг үргэлжлүүлэн ярьсан юм.

Бахархалтайгаар нээлттэй амьдардаг хүмүүс сайн сайхан амьдарч байна гэдэг л хамгийн чухал. Сошиал медиа дахь постуудынх нь доор найзууд нь гоё, инээдтэй зүйлс бичиж, тэд хамт инээж хөөрдөг. Олон нийт маань намайг жаргалтай болгодог. Бахархалтайгаар нээлттэй амьдарч буй хүмүүсийг харах нь өөртөө итгэх итгэлийг минь нэмэгдүүлж, би ч бас ирээдүйд тэдэн шиг бардам алхаж амьдрах болно гэх бодлыг төрүүлдэг. Бас бид стрэйт хүмүүсийг бодвол илүү загварлаг. Монголын Күйр Подкаст долоо хоног бүрийн Баасан гарагт шинэ дугаар гаргадаг. Баасан гарагийг хүлээх нь миний хувьд амьдралд хайртай байх, зорилготой байх утга учир болдог.

Монголын ЛГБТИК+ эрхийн тэмдэглэлт өдрүүд болох Тэгш эрх, бахархлын өдрүүдийг зарим оролцогчид талархан онцолж байв. Эдгээр үйл явдлууд нь тэднийг нийгэм дэх тэгш бус байдал болоод өөрсдийн шударга ёсны мэдрэмжийн талаар эргэцүүлэн бодоход хүргэсэн гэж байв.

Баяр (транс хөвгүүн, 16 настай):

Тэгш эрх, бахархлын өдрүүд Монголд намар болгон зохион байгуулагддаг гэдгийг би мэднэ. Сүүлийн жилүүдэд тэмдэглэн өнгөрүүлэхэд зориулсан үйл ажиллагаанууд илүү хүч, далайцтай болсноор олон нийтийн сөрөг хандлагыг татаад буй. Миний бодлоор бид Монголд өөрсдийн оршин буйг мэдэгдэж байх нь чухал. Хэрэв бид Монголд ямар ч ЛГБТ хүн байдаггүй юм шиг чив чимээгүй байвал нийт иргэд төдийгүй ЛГБТ хүмүүс нь өөрсдөө ч ЛГБТ асуудлаараа ямар ч ойлголттой болж чадахгүй шүү дээ. Бусад хүмүүс, олон нийт өөрсдийн эрхийн төлөө жагсаж тэмцэж болж байгаа бол бид яагаад болохгүй гэж?

МЭДЭЭЛЭЛ ОЛЖ АВАХ

Бид өмнөх бүлгүүдэд дурдаж байсанчлан сурагч бүр мэдээлэл эрэлхийлэх, хүлээн авах, хандах, хуваалцах эрхтэй билээ. Өнөө үед сошиал медиа өсвөр залуу үеийнхний өдөр тутмын амьдралын нэг хэсэг болсон төдийгүй транс сурагчдад өөрсдийн хүйсийн баримжаа, илэрхийллийнхээ тухай болон бусад олон төрлийн мэдээлэл олж авахад голлох үүрэг гүйцэтгэж байна. Цаашилбал, ЛГБТИК+ өсвөр залуу үеийнхний сошиал медиагаар дамжуулан мэдээлэл олж авах боломж хялбаршсан нь ахмад түрүү үеийнхэнтэй нь харьцуулахад тэдний амьдралыг илүү эерэг, амар хялбар болгож байна (Ганбаатар ба бусад, 2021). Сошиал медиагаар дамжуулан транс залуу үе илүү нээлттэй, ил харагдаж, эх хэлээрээ зохистой мэдээлэл олж авч, өөрөө нэг хэсэг нь гэж мэдрэх олон нийтээ ч олох боломжтой болжээ. Өөртэйгөө адил хүмүүс буюу өөрийн олон нийтээ олох нь тэдэнд эерэг мэдрэмж төрүүлэхээс гадна өөртөө итгэх итгэлийг нь ч дээшлүүлэхэд тустай байдаг (Ганбаатар ба бусад, 2021). Гэсэн хэдий ч транс өсвөр залуу үеийнхэнд ашиг тустай олон зүйлтэй зэрэгцэн цахим орчинд хуурамч ташаа мэдээлэл, цахим дээрэлхэлт улам их тархаж байна.

Хантүшиг (нонбайнари, 16 настай):

Хүмүүс Инстаграм дээр надад дуртай байгаагаа илэрхийлдэг болсон. Би хамгийн сайн найзаа Инстаграмаас олсон. Күйр театрын нэг постер сторидоо хуваалцтал тэр над руу зурвас бичиж, түүнээс хойш бид хамгийн сайн найзууд болсон. Өөрийн хүйсийн баримжааг ил болгож эхэлснээс хойш би анги16 хүмүүсийг татаж байгаа юм шиг санагдах болсон. Жишээлбэл, миний уулзсан хүмүүсийн бараг 30 хувь нь күйр хүмүүс. Тэгээд тэд ч бас нээлттэй болж эхэлсэн нь үнэхээр гоё.

Жолие (транс охин, 16 настай):

Өөрийн хүйсийн баримжааны талаар анх мэдмэгцээ би монгол хэлээр YouTube болон Facebook-ээс мэдээлэл олж авах гэж хайж үзсэн. Facebook дээрх хайлт маш муухай, сөрөг үр дүнтэй байсан. Трансжендер хүмүүсийн тухай би маш олон сөрөг мэдээ, нийтлэл олсон.

Транс сурагчдын хувьд мэдээлэл олж авахад нөлөөлж буй өөр нэг хүчин зүйл нь хэл, ялангуяа англи хэл юм. Бэлгийн мөн чанар, жендерийн талаарх ойлголтууд ихэвчлэн англи хэлээр бичигдсэн байх ба хамгийн дэвшилтэт нэр томъёонууд ч мөн тус хэл дээр хөгжин баяжиж байдаг. Тиймээс зарим транс сурагчдын хувьд англи хэл мэдэх нь жендерийн тухай ойлголт, өөрийн трансжендер баримжаа илэрхийлэлтэй холбоотой мэдээлэл олж авахад давуу тал болдог байна. Хувийн сургуульд сурдаг сурагчид англи хэлээр сайн ярьдаг ба тэдний мэдээлэл олж авах боломж англи хэлээр ярьдаггүй улсын сургуулийн сурагчдынхтай харьцуулахад хавьгүй илүү байв. Цаашилбал, англи хэлээр ярьдаг сурагчид илүү өөрийгөө хүлээн зөвшөөрөх, өөртөө итгэлтэй байх хандлагатай байна.

Синди (транс охин, 16 настай):

Би ихэвчлэн англи хэлээр мэдээлэл олж авдаг. Мэдэхгүй зүйл байвал шууд л Google хайлтын хэрэгсэл рүү ордог. Англи, Америкийн соёл сүүлийн үед күйр хүмүүст ихээхэн ээлтэй болж байгаа. Күйр хүмүүсийн тухай маш их мэдээлэл байдаг. Энэ бүхэн нь сэтгэцийн өвчин биш гэдгийн баталгаа гэх юм уу. Тиймээс өмнө хэлж байсанчлан англи хэл мэддэг байх нь миний бодлоор намайг дэмжиж ойлгодог олон хүнийг олоход дөхөмтэй. Англи хэл гэсэн давуу тал байгаагүй бол би ч өнгөрсөн байх байлаа. Бусад хүмүүс англи хэл мэдэхгүйгээр яаж мэдээлэл олж авдгийг мэдэхгүй юм.

16 ЛГБТИК+ олон нийтийн хувьд өөрсдийгөө анги гэдэг үгээр өөрсдийгөө ЛГБТИК+ олон нийтийн нэг гэж илэрхийлэх нь элбэг байдаг.



Игги

(транс хөвгүүн, 17 настай):

Би 3 дугаар ангиасаа эхлэн англи хэл сурч эхэлсэн, тэгээд Tumblr дээр бүртгэлтэй болсон. Тэнд олон төрлийн цахим орчин дахь олон нийт байдаг ба тэндээс минийхтэй адил зүйл амсаж туулсан хүмүүсийн амьдралын туршлагын тухай уншдаг. Мэдээллүүд ихэвчлэн англи хэлээр байдаг. Мэдээж хэрэг Tumblr учраас би нэг их бэлгийн болон хүйсийн олон янз байдлын талаар шинжлэх ухаанч баримт мэдээ олж авна гэж боддоггүй, зүгээр л над шиг хүмүүс юу амсаж туулж байгааг олж мэдэх нь надад тайвшрал өгдөг юм.

НАЙМДУГААР БҮЛЭГ:

Дүгнэлт, зөвлөмж

ДУГНЭЛТ

Энэхүү чанарын судалгааны үр дүнд гарсан дүгнэлтүүд бүгд туйлын хор хөнөөлтэй байсаар байгаа багш сурган хүмүүжүүлэгчдийн хандлага, сургуулийн орчны талаар шүүмжтэй эргэцүүлэмж огт байхгүй байгааг илтгэж байна. Ийнхүү хэзээ ч шүүмжлүүлж үзээгүй үндэсний боловсролын систем дэх хүйсийн хэвшмэл байдлыг өөрчлөх томоохон сорилт транс сурагчдын өмнө үлдэв. Хүйсээр ангилан хуваах нь сургуулийн орчинд ил тод хэрэгжиж байдаг бөгөөд өдөр тутмын заах аргазүйн үйл явцаас эхлээд сургуулийн анги танхим, материаллаг бааз хүртэл өөрчлөлтөд хариг энэхүү соёл боловсролын системийн бүрдэл хэсэг бүрд нэвчин оршсоор байна. Судалгааны үр дүнд үндэслэн дүгнэхэд сургуулийн орчинд транс сурагчдад чиглэсэн ямар нэг дэмжлэг туслалцаа үгүй бөгөөд сурагчдад бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжааны талаар сүүлийн 20 жилийн турш зааж байгаа боловч багш нарын ЛГБТИК+ сурагчдад хандах хандлагад төдийлөн эерэг өөрчлөлт гараагүй байна. Хэдийгээр бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжааны тухай сэдэв 9 дүгээр ангийн эрүүл мэндийн боловсролын хичээлийн хөтөлбөрт багтсан боловч багш нар ихэвчлэн энэ сэдвийг алгасах, заасан ч заах аргазүйн хувьд зарим талаар сөрөг, ялгаварлан гадуурхах хандлагатай байсаар байна. Цашилбал, оролцогчдын олонх нь багш, гэр бүлийн гишүүд, үе тэнгийн хүүхдүүд, үл таних хүмүүсийн зүгээс үг хэл, бие махбодын хүчирхийлэл, тэр бүү хэл бэлгийн дарамт амсаж байгаа нь тэдний сэтгэцийн эрүүл мэнд доройтсонтой, ялангуяа сэтгэл гутрал, ганцаардал, өөрийгөө гэмтээх, амиа егүүтгэх зэрэг эрсдэлд өртөмхий байгаатай нягт холбоотой юм. Сэтгэцийн эрүүл мэндийн зөвлөгөө үйлчилгээ авах боломжгүй байх, сөрөг таагүй үйл явдлууд тохиолдох, түүнчлэн багш, сургуулийн сэтгэлзүйчдэд үл итгэх зэргээс үүдэн дээр дурдсан эрсдэлд өртөмтгий байснаар дийлэнх транс сурагчид тусламж дэмжлэг эрэлхийлэхээс зайлсхийдэг аж. Эцэг эхийн зүгээс дэмжлэг үзүүлдэг хэмээн дийлэнх нь хариулаагүй бөгөөд харин ч трансжендер хүмүүсийн талаарх гэр бүлийн гишүүдийн хандлага ихэвчлэн сөрөг байдлаар дурдагдсан нь транс сурагчдын сэтгэцийн эрүүл мэнд доройтох гол хүчин зүйл болж байна хэмээн дүгнэж болохоор байна. Цахим орчинд өөрсөдтэйгөө адил олон нийтийг олсноор өөрийгөө тодорхой олон нийтийн нэг хэсэг хэмээн мэдрэх нь, түүнчлэн хамгийн энгийн хэлбэрээр ЛГБТИК+ эрхийн хөдөлгөөнд хувь нэмрээ оруулж, оролцох нь транс сурагчдын эрүүл энх, сайн сайхан аж төрөхүйг хамгаалах эерэг хүчин зүйл болдог аж.

ЗӨВЛӨМЖ

Дараах зөвлөмжийг энэхүү кэйс цуглуулгын судалгааны оролцогчдын туршлага дээр үндэслэн бэлтгэн гаргасан болно. Зөвлөмж нь илүү хүртээмжтэй, аюулгүй орчин буюу транс сурагчдад ээлтэй сургуулийн уур амьсгалыг бий болгох замаар транс сурагчдын даван туулах эрмэлзэл, сэтгэцийн болон биеийн ерөнхий эрүүл мэнд, сайн сайхныг дэмжих зорилготой юм.

ТӨРИЙН БАЙГУУЛЛАГА, ЗАСГИЙН ГАЗРЫН АГЕНТЛАГУУДАД

- Хүйсийн тэгш байдлын тухай хуулийг бүх салбар, тэр дундаа боловсролын системд бодитоор хэрэгжүүлэх
- Транс хүмүүст зориулсан Үндэсний эрүүл мэнд хамгааллын стандартыг боловсруулж, сэтгэцийн эрүүл мэндийн чиглэлээр голлон үйлчилгээ үзүүлж буй эрүүл мэндийн салбарын ажилтан мэргэжилтнүүдийг зохих сургалт мэдээллээр хангах
- Бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжааны талаарх агуулга бүхий эрүүл мэндийн боловсролын хичээлийн сургалтын хөтөлбөрийн чанарт зохих мониторинг, үнэлгээг хийх
- Хүйсээр ангилан хуваах сургуулийн бодлогыг халж, транс болон хүйсийн олон янз байдал бүхий сурагчдыг дэмжих нийцтэй бодлого, зааварчилгаагаар сургуулийн бүх нэгдэл хэсгийг хангах
- Холбогдох хичээлүүдэд, ялангуяа технологи, зохион бүтээх хичээлд хэрэглэгдсээр буй хүйсээр ангилан хуваах үеэ өнгөрөөсөн зохион байгуулалтын арга хэлбэрийг өөрчилж, шинэ зохион байгуулалтын шийдэл танилцуулах
- Сургуулиудыг дээрэлхэлтийн эсрэг ялангуяа бэлгийн болон хүйсийн олон янз байдлын талаар тусгайлан анхаарсан бодлого, дүрэм журамтай болгох
- Багш сурган хүмүүжүүлэгчид, нийгмийн ажилтан, сэтгэлзүйч болон сургуулийн бусад бүх ажиллагсдыг үе тэнгийн дээрэлхэлт, нийгмийн гишүүдийн олон янз байдал, транс жендер хүмүүстэй холбоотой сэдвээр цогц сургалтад хамруулах

СУРГУУЛЬ, БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГЫН МЭРГЭЖЛИЙН АЖИЛТНУУДАД

- Багш сурган хүмүүжүүлэгчид болон сургуулийн удирдлагуудыг зохих сургалтад хамруулах, үүнд зориулсан төсвийг хангалттай хүрэлцэхүйцээр төлөвлөх
- Өөрийн эрх мэдлийн хүрээнд транс сурагчдад аюулгүй, ээлтэй уур амьсгал бүрдүүлэх чиглэлээр ач холбогдолтой үйл ажиллагаа зохион байгуулах, ялангуяа транс сурагчдын хэрэгцээ шаардлагад мэдрэмжтэй хандаж хүйс онцлон заагаагүй ариун цэврийн өрөөг бий болгох

- Сургуулийн дүрэмт хувцасны бодлогыг өөрчилж, транс сурагчид өөрийн хүйсийн баримжаандаа нийцсэн хувцас өмсөх боломжтой дүрэм журмыг шинээр бий болгох
- Эрүүл мэндийн боловсролын хичээл заах бүтэн цагийн үндсэн багшийн орон тоог бий болгохын зэрэгцээ одоо байгаа багш нарыг бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаатай холбоотой сэдвийг заах зохих сургалтаар хангах
- Сургуулийн нийгмийн ажилтан, сэтгэлзүйчид транс сурагчдад зөвлөгөө дэмжлэг үзүүлэхдээ тэдний хувийн нууцыг чандлан хадгалах

СЭТГЭЦИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРЫН МЭРГЭЖИЛТНҮҮДЭД

- Хүйсийн олон янз байдал, трансжендер хүмүүстэй холбоотой асуудлаар модуль сургалтын хөтөлбөр боловсруулж сэтгэцийн эрүүл мэндийн чиглэлээр бэлтгэгдэж буй, энэ чиглэлээр ажиллаж буй мэргэжилтнүүдийн дунд сургалт зохион байгуулах
- Сэтгэцийн эрүүл мэндийн оношилгоо, эмчилгээ, үйлчилгээнд Олон улсын Өвчний Ангилал 11-ийг нэвтрүүлэх
- Трансжендер хүмүүст тулгамддаг асуудлаар мэргэшсэн сэтгэцийн эрүүл мэндийн мэргэжилтнүүдийн сүлжээг бий болгож сургуулийн сэтгэлзүйч өөрийн үүрэг, чадавхаас хэтэрсэн нөхцөл байдал үүсэх үед сурагчдад мэргэжлийн сэтгэлзүйн эрүүл мэндийн мэргэжилтэн санал болгох боломжийг бүрдүүлэх
- Трансжендер болон хүйсийн олон янз байдал бүхий хүмүүсийн эсрэг ямар нэг зохисгүй авир, үйлдэл гарсантай холбоотой ирсэн гомдол саналд түргэн шуурхай, зохистой байдлаар хариулах, хариу арга хэмжээ авах
- Трансжендер болон хүйсийн олон янз байдал бүхий хүүхдүүдийн эцэг эхийг хамт олны дэмжлэг, дотоод дахь хамтын бүлэг, тэдгээрийн байгууллагуудын тухай мэдээллээр хангах

ЦААШ СУДЛАХ НЬ

- Хотын захын хороолол, алслагдмал аймаг суманд амьдран суугаа транс сурагчдын амсаж туулж буй амьдралын туршлагын талаар нэмж дэлгэрүүлэн судлах
- Монгол дахь транс залуу үеийн эрүүл мэндийн хэрэгцээ, хамгаалах хүчин зүйлийн талаар тусгайлан судлах
- Транс болон хүйсийн олон янз байдал бүхий өсвөр залуу үеийн туршлагын талаар эрүүл мэнд, хүний нөөц, нийгмийн ажилтан гэх мэт халамжийн мэргэжилтнүүдтэй хэлэлцэж хамгааллын тохиромжтой загварыг олж тогтоох
- Транс сурагчдын амсаж туулж буй гэр бүлийн хүрээний хүчирхийлэл, үе тэнгийн дээрэлхэлтийн талаар нэмж дэлгэрүүлэх судлах

REFERENCE LIST

- Barcelona, D., Laski, L., & Gerds, C. (2002). Universal sexuality education in Mongolia: Educating today to protect tomorrow. https://knowledgecommons.popcouncil.org/cgi/viewcontent.cgi?article=1032&context=departments_sbsr-pgy
- Beautiful Hearts Against Sexual Violence. (2019). Official Request to stop "Girls' physical examination". <https://www.facebook.com/btifulhearts/posts/1939236739541856/>
- Davaasambuu, S., Batbaatar, S., Witte, S., Hamid, P., Oquendo, M. A., Kleinman, M., ... & Gould, M. (2017). Suicidal plans and attempts among adolescents in Mongolia. *Crisis*.
- Davaasambuu, S., Phillip, H., Ravindran, A., & Sztamari, P. (2019). A scoping review of evidence-based interventions for adolescents with depression and suicide-related behaviours in low and middle-income countries. *Community mental health journal*, 1-19.
- Devereux, G. 1937. "Institutionalized Homosexuality of the Mohave Indians." *Human Biology* 9 (4): 498–527.
- Fredrickson, B. L., M. A. Cohn, K. A. Coffey, J. Pek, and S. M. Finkel. 2008. "Open Hearts Build Lives: Positive Emotions, Induced Through Loving-Kindness Meditation, Build Consequential Personal Resources." *Journal of Personality and Social Psychology* 95 (5): 1045–1062. doi:10.1037/a0013262.
- Frohard-Dourlent, H. (2016). 'I don't care what's under your clothes': The discursive positioning of educators working with trans and gender-nonconforming students. *Sex education*, 16(1), 63-76. <https://doi.org/10.1080/14681811.2015.1022819>
- Frohard-Dourlent, H. (2018). 'The student drives the car, right?': Trans students and narratives of decision-making in schools. *Sex Education*, 18(4), 328–344. <https://doi.org/10.1080/14681811.2017.1393745>
- Ganbaatar, D., Vaughan, C., Akter, S., & Bohren, M. A. (2021). Exploring the identities and experiences of young queer people in Mongolia using visual research methods. *Culture, Health & Sexuality*, 1-18. <https://doi.org/10.1080/13691058.2021.1998631>
- Grossman, A. H., & D'augelli, A. R. (2006). Transgender youth: Invisible and vulnerable. *Journal of homosexuality*, 51(1), 111-128.
- Grossman, A. H., D'Augelli, A. R., & Dragowski, E. A. (2014). Caregiving and care receiving among older lesbian, gay, and bisexual adults. In *Caregiving with pride* (pp. 15-38). Routledge.
- Grossman, A. H., Park, J. Y., & Russell, S. T. (2016). Transgender youth and suicidal behaviors: Applying the interpersonal psychological theory of suicide. *Journal of gay &*

lesbian mental health, 20(4), 329-349.

Horowitz, A., & Hansen, A. (2008). Out for equity: School-based support for LGBTQA youth. *Journal for LGTB Youth*, 5(2), 73–85. doi:10.1080/19361650802092457

Labour Law (2021). Article 6. Prohibition of discrimination in employment and labor relations. <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16230709635751>

Lindner, A. (2014). Familial support and celebration of gender nonconforming children. *Sex Roles* 70, 442–444. <https://doi.org/10.1007/s11199-014-0363-y>

Lenning, E., & Buist, C. L. (2013). Social, psychological and economic challenges faced by transgender individuals and their significant others: Gaining insight through personal narratives. *Culture, health & sexuality*, 15(1), 44-57.

McNeil, J., Bailey, L., Ellis, S., Morton, J., & Regan, M. (2012). Trans mental health study 2012. Scottish Transgender Alliance. https://www.scottishtrans.org/wp-content/uploads/2013/03/trans_mh_study.pdf

Ministry of Education, and Science. (2019). Basic Education Program, Second Revised Edition. <https://cdn.greensoft.mn/uploads/users/2649/files/Curriculum/EBS/Suuri.pdf>

Miranda-Mendizábal, A., P. Castellví, O. Parés-Badell, J. Almenara, I. Alonso, M. J. Blasco, A. Cebrià, A. Gabilondo, M. Gili, C. Lagares, et al. 2017. "Sexual Orientation and Suicidal Behaviour in Adolescents and Young Adults: Systematic Review and Meta-Analysis." *The British Journal of Psychiatry* 211 (2): 77–87. doi:10.1192/bjp.bp.116.196345

Naymdorj, A., & National Human Rights Commission of Mongolia. (2013). Implementation of the rights of sexual minorities in Mongolia.

Nyamdorj, A. 2006. Life Denied: LGBT Human Rights in the Context of Mongolia's Democratisation & Development. http://www.afdenver.net/documents/LGB-THRinMNG_Anaraa.pdf

Noddings, N. (2005a). Identifying and responding to needs in education. *Cambridge Journal of Education*, 35, 147–159. doi:10.1080/03057640500146757

Russon, J., Smithee, L., Simpson, S., Levy, S., & Diamond, G. (2022). Demonstrating attachment based family therapy for transgender and gender diverse youth with suicidal thoughts and behavior: a case study. *Family process*, 61(1), 230-245.

Singh, A. A., Meng, S. E., & Hansen, A. W. (2014). "I am my own gender": Resilience strategies of trans youth. *Journal of counseling & development*, 92(2), 208-218.

Shields, C. M. (2004). Dialogic leadership for social justice: Overcoming pathologies of silence. *Educational Administrative Quarterly*, 40, 109–132. doi:10.1177/0013161x03258963

Shlasko, G. D. 2005. "Queer (v.) Pedagogy." *Equity & Excellence in Education* 38 (2): 123–134. doi:10.1080/10665680590935098.

Stotzer, R. L. (2009). Violence against transgender people: A review of United States data. *Aggression and Violent Behavior*, 14(3), 170-179.

Symons, C., O'Sullivan, G., Borkoles, E., Andersen, M. B., & Polman, R. C. (2014). The impact of homophobic bullying during

- sport and physical education participation on same-sex attracted and gender diverse young Australians' depression and anxiety levels.
- Tsedendemberel, O. (2011). All for Education National Coalition: Implementation of the right to education among sexual minority adolescents and youth: compilation and analysis of case studies. https://www.researchgate.net/publication/304179884_Belgijn_cnhijn_hhed_zaluusyn_surc_bolovsroh_erh_herhen_hangagdaz_bajna_ve_Kejs_cugluulga_Dn_sinzilgee_2_Implementation_of_the_right_to_education_among_sexual_minority_adolescents_and_youth_compilation
- Terbish, B. 2013. "Mongolian Sexuality: A Short History of the Flirtation of Power with Sex." *Inner Asia* 15 (2): 243–271. doi:10.1163/22105018-90000069
- The State of Mongolia (2021, December 17). Law on Personal Data Protection. <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16390288615991>
- The LGBT Centre (Mongolia). (2016). Youth Leadership for Human Rights Program-2016 Report. <https://lgbtcentre.mn/en/2017/06/08/youth-leadership-human-rights-program-2016-report/>
- The LGBT Centre (Mongolia). (2019).
- The LGBT Centre (Mongolia). (2022). Protection of the Rights of LGBTI persons. Shadow Report submitted to the UN Committee on the Economic, Social, and Cultural Rights.
- The Ministry of Education (2022). Professional code of ethics for teacher and staff of pre-school and general education institutions. <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16532345574681&showType=1>
- Ulemj, A. (2018, August 31). Six topics of Health Education Class that will be taught in 4-12th grades at school. Ikon News. <https://ikon.mn/n/1dez>
- UNICEF Mongolia. (2019). MONGOLIA EDUCATION Sectoral and OR+ (Thematic) Report January – December 2018. <https://open.unicef.org/sites/transparency/files/2020-06/Mongolia-TP5-2018.pdf>
- United Nations. (2015, December 10). UN Free & Equal: Price of Exclusion. [Video]. YouTube. <https://www.youtube.com/watch?v=DvSxLHpyFOk>
- United Nation, (2017). Committee on the Rights of the Child: Concluding observations on the fifth periodic report of Mongolia. <https://digitallibrary.un.org/record/1311385?ln=en>
- UNESCO. (2020). Mongolia, Education Policy Review: Towards a Lifelong Learning System. <https://unesdoc.unesco.org/ark:/48223/pf0000373687/PDF/373687eng.pdf.multi>
- UNDP, USAID. (2014). Being LGBT in Asia: Mongolia Country Report. <https://www.refworld.org/pdfid/54ed84be4.pdf>
- Unurzul, M. (2020, October 21). Health Education Issues Discussed. Montsame, Mongolian News Agency. <https://montsame.mn/en/read/240277>